



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨХ БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

/Төв аймгийн жишээн дээр/

Судалгааны багийн ахлагч: Ж.БАРИАШИРСҮРЭН
Судлаачид: Ж.АРИУНЦЭЦЭГ, Б.ДОРЖПАГМА

Улаанбаатар хот
2015 он



ШҮҮХИЙН ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨХ
БОДЛОГЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
/Төв аймгийн жишээн дээр/

Судалгааны багийн ахлагч: Ж.БАРИАШИРСҮРЭН
Судлаачид: Ж.АРИУНЦЭЦЭГ, Б.ДОРЖПАГМА

© Нээлттэй Нийгэм Форум, 2015
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -14240
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

DDC
340
Б-291

ISBN: 978-99962-77-78-8

ТАЛАРХАЛ.....	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
УДИРТГАЛ	7
БҮЛЭГ 1. Монгол Улсын шүүхийн тойргийн тогтолцоог өмнөх тогтолцоотой харьцуулсан байдал.....	14
1.1. Монгол улсын шүүхийн тогтолцоо I.....	14
1.2. Монгол Улсын шүүхийн тогтолцоо II.....	16
1.3 Шүүхийн тогтолцооны шинэчлэлийн үр нөлөө, тулгамдаж буй асуудал.....	20
1.4. Шүүхийн ачаалал, шүүхийн шийдвэрийн чанарт гарсан өөрчлөлт	27
1.5 Дэд хэсгийн дүгнэлт	32
БҮЛЭГ 2. Шүүхийн тогтолцооны өөрчлөлтийн талаарх иргэдийн ойлголт, хандлага.....	35
2.1. Шүүхийн тогтолцооны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл	37
2.2. Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин	40
2.3. Дэд хэсгийн дүгнэлт	42

БҮЛЭГ 3. Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр гарч буй үр дагавар, тулгарч буй хүндрэл бэрхшээл.....	44
3.1 Зардал, цаг хугацааны хувьд үр ашигтай байдал	44
3.2.Дэд хэсгийн дүгнэлт	55
ДҮГНЭЛТ	56
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	61
ЭХ СУРВАЛЖ	65
ХАВСРАЛТ	67
Хавсралт № 1. Судалгааны нэгдсэн дүн.....	67
Хавсралт № 2. Монгол Улсын шүүхийн шинэтгэлүүд буюу шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтүүд	72
Хавсралт №3. Төв аймгийн Зуун мод сум дахь шүүхийн төсөв	74

ТАЛАРХАЛ

Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүхийн шинэтгэлийг дэмжих төслийн хүрээнд хийгдсэн “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ” ажлыг амжилттай гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн дараах хамт олныг дурдахад таатай байна.

Сум дундын 23 дугаар шүүх, Дүүргийн иргэний хэргийн 4 дүгээр шүүхийн Тамгын газар, Төв аймгийн Дэлгэрхаан, Жаргалант, Борнуур сумдын Засаг даргын тамгын газар, мөн судалгаанд оролцсон шүүгч, өмгөөлөгч, прокурор, цагдаа болон иргэдийн төлөөлөлд талархал илэрхийлье.

Мөн биднийг энэхүү судалгааны ажлыг хийхэд дэмжлэг үзүүлсэн ННФ-ын хамт олон, Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаад талархсанаа илэрхийлье.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ННФ	Нээлттэй Нийгэм Форум
УИХ	Улсын Их Хурал
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
АШШ	Анхан шатны шүүх
ДИХАШШ	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх
ДЭХАШШ	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
СДШ	Сум дундын шүүх
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
ХШШ	Хяналтын шатны шүүх
УДШ	Улсын дээд шүүх
ҮХЦ	Үндсэн хуулийн Цэц
ҮХ	Үндсэн хууль
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

УДИРТГАЛ

Оршил

Улсын Их Хурлаас 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр” болон 2000 онд баталсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтын¹ дагуу Улсын Их Хурлаас (цаашид УИХ гэх) 2012 онд Шүүхийн тухай багц хууль буюу Монгол Улсын Шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Шүүхийн захиргааны тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулиудыг тус тус баталсан бөгөөд эдгээр хууль тогтоомжийг 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

УИХ-аас 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталж 2013 оны 4 дүгээр сараас эхлэн дагаж мөрдөж буй Шүүхийн тухай, Шүүх байгуулах тухай хуулиуд болон бусад эрх зүйн актын хүрээнд хяналтын шатны шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, суурьшлын харилцан уялдсан тогтолцоо, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулсан билээ. Өнөөдөр Монгол Улсад давж заалдах шатны 21 шүүх /цаашид ДЗШШ гэх/², анхан шатанд 57 шүүх³

¹ “Монгол Улсын Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах бусад хуулийн төслийн үзэл баримтлал” Цахим хуудас: www.parliament.mn/files/download/14865

² Иргэний хэргийн ДЗШШ 10, Эрүүгийн хэргийн ДЗШШ 10, Захиргааны хэргийн ДЗШШ 1, нийт 21 шүүх байгуулагдсан.

³ Дүүргийн иргэний хэргийн АШШ 4, дүүргийн эрүүгийн хэргийн АШШ 4, захиргааны хэргийн АШШ 20, Сум дундын шүүх 29, нийт 57 шүүх байгуулагдсан.

/цаашид АППШ гэх/ шинэчлэгдэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна⁴. Үүний зэрэгцээ шинээр үүссэн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шүүгчийн орон тоо, шүүхийн төсөв, шүүгчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш 2 жил гаруй хугацаа өнгөрлөө.

Шүүхийн шинэчлэлийн үр дүнд нэг аймгийн сумд шүүхийн харьяаллын хувьд хэд хэдэн өөр аймгийн шүүхэд хамаарах болсон, өөрөөр хэлбэл нэг шүүх хэд хэдэн аймгийн сумдын хэргийг харьяалан шийдвэрлэх болсон. Энэхүү өөрчлөлт эрх ашгаа хамгаалуулах, хөндөгдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандаж буй иргэдэд өнгөрсөн 2 жилийн хугацаанд ямар, ямар үр дагавар учруулж байгааг тогтоосноор шүүхийн шинэчлэл, түүн дотроо шүүхийн тогтолцоог өөрчилсөн бодлогын шийдвэрийн хэрэгжилт иргэд олон нийтэд хэрхэн нөлөөлж, хүрч байгаад дүгнэлт өгөхөд нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Иймд иргэдэд хүрч, мэдрэгдсэн өөрчлөлтүүдийг нэг талаас шүүхийн шинэчлэлийн талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох, нөгөө талаас иргэдийн эдийн засгийн байдалд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох буюу зардал-үр өгөөжийн харьцааг тооцоолох замаар шүүхийн шинэчлэлийн явцад гарсан давуу тал, ололт амжилт, алдаа дутагдал зэрэг асуудлыг зохих хэмжээнд тодорхойлох, хууль хэрэгжилтийн түвшинд буюу бодит нийгмийн харилцаанд ямар эерэг үр дүн, сөрөг нөлөө үзүүлж байгааг Төв аймгийн жишээгээр харуулахыг зорилоо.

Жишээ болгон авсан Төв аймгийн сумд шүүхийн өмнөх тогтолцооны үед буюу 2013 оны 4 дүгээр сараас өмнө хэргийн анхан шатанд Төв аймгийн Сум дундын 1, 2 дугаар шүүхээр, хэргийн давж заалдах шатанд Төв аймгийн шүүхээр үйлчлүүлдэг байсан. Харин шинэ тогтолцоонд шилжсэнээр хэргийн анхан шатанд Багануур, Налайх дүүрэг дэх Дүүргийн иргэний хэргийн 3, 4 дүгээр шүүх, Дүүргийн эрүүгийн хэргийн 3, 4 дүгээр шүүх болон Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын 18 дугаар шүүх, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын 21 дүгээр шүүх, Төв аймгийн Зуунмод сум дахь Сум дундын 23 дугаар шүүхэд харьяалагдах болсноор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл байсан 27 сум шүүхийн харьяаллын хувьд 5 тасарсан байдаг. Хэргийн давж заалдах шатанд

⁴ 2013 оны 4 дүгээр сарын 15-наас хэрэгжиж эхэлсэн “Шүүх байгуулах тухай хууль”- тай холбогдуулан ҮХЦ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Шүүх байгуулах тухай хуулийн 1,2 дугаар зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 1 дүгээр тогтоолоор хүчингүйд тооцсоны дагуу 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн “Шүүх байгуулах тухай хууль” дахин шинэчлэгдэн батлагдсан.

Дархан-Уул аймгийн Дархан хот, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Улаанбаатар хотод тус тус байрлах иргэний хэргийн давж заалдах шатны 4, 9, 10 дугаар шүүх, эрүүгийн хэргийн давж заалдах шатны 4, 9, 10 дугаар шүүх гэсэн 3 өөр шүүхээр үйлчлүүлэх болсон.

Иймд энэхүү судалгааны ажил нь нутаг дэвсгэрийн хувьд зэргэлдээ орших боловч шүүхийн харьяаллын хувьд 2 өөр шүүхэд хандах шаардлагатай Төв аймгийн Эрдэнэсант, Дэлгэрхаан, Жаргалант, Цээл, Борнуур сумдын иргэдийг зорилтот бүлэг болгон сонгосон бөгөөд зорилтот бүлгийн иргэдээс авсан анкетын судалгаа болон сонгогдсон бүс нутгийн шүүхүүдээс буюу Төв аймаг дахь Сум дундын 23 дугаар шүүх, Налайх дүүрэг дэх Дүүргийн иргэний хэргийн 4 дүгээр шүүх, Дүүргийн эрүүгийн хэргийн 4 дүгээр шүүх болон Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын 21 дүгээр шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан болон өмгөөлөгч, прокурор, цагдаагийн албан хаагч нараас авсан ганцаарчилсан ярилцлагын буюу чанарын судалгаанд суурилсан болно.

Судалгааны зорилго

Тус судалгааны ажлын зорилго нь шүүхийн бүтэц, тогтолцоог бүхэлд нь шинэчилж шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан нь өргөн уудам нутаг дэвсгэртэй манай орны хувьд хөдөө, орон нутагт амьдарч буй иргэд хөндөгдсөн эрх ашгаа хамгаалуулахаар шүүхэд хандах, шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхээ эдлэх нөхцөлийг хэрхэн хангаж байгааг тодруулах, мөн шүүхүүдийн харилцан адилгүй ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгч хэргийн төрлөөр дагнан мэргэших, шийдвэрийн чанарыг сайжруулах зорилгоор шүүхийг дагнан, бүсчлэн байгуулсан явдал нь шүүх байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ойртож, тэдний эрх ашигт нийцэж байгаа эсэхийг тогтоох, үүнээс гадна иргэдэд үүсэж буй эдийн засгийн буюу зардлын үр нөлөөг тооцоход оршино.

Судалгааны мэдээлэл цуглуулах арга

“Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ” судалгааны ажлыг гүйцэтгэхэд анкет буюу санал асуулгын арга, ганцаарчилсан ярилцлагын арга болон баримт бичиг шинжлэх аргыг тус тус ашигласан болно.

Анкетийн арга: Анкет нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой нийгмийн судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Тиймээс энэхүү

судалгаанд анкетын аргаар шүүх байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлж, шүүх ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, сайжруулах арга замын талаарх санал бодол, зөвлөмж болон шүүмж зэрэг мэдээллүүдийг цуглуулсан. Анкетын судалгаанд Төв аймгийн Эрдэнэсант, Дэлгэрхаан, Жаргалант, Цээл, Борнуур сумдын шүүх байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийг хамруулав.

Ганцаарчилсан ярилцлагын арга: Энэ нь чанарын судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Ганцаарчилсан ярилцлагын арга нь анкетын аргаар авсан мэдээллийн учир шалтгаан, мөн чанар, дотоод зүй тогтлыг илэрхийлэн гаргахад ихээхэн үр дүнтэй байдаг. Тиймээс энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргаар анкетын судалгааны мэдээллийн учир шалтгааныг нь тодорхойлох мэдээллүүдийг Төв аймгийн иргэдийн хэрэг, маргааныг шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй шүүгч/шүүхийн захиргааны ажилтан, өмгөөлөгч, прокурор болон цагдаагийн албан хаагч нараас цуглууллаа.

Баримт бичгийн шинжилгээний арга: Баримт бичиг судлах буюу шинжлэх арга нь объектив шинжтэй учраас судлаачдад илүү бодитой мэдээлэл өгдөг онцлогтой. Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгүүдийг дараах ангилалд оруулан шинжилгээ хийхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Эрх зүйн үндэслэл буюу хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн хэрэгжилт болон түүний зорилгод хүрэх байдлыг танилцуулна.
2. Эдийн засгийн үндэслэл буюу зардал, үр өгөөжийн харьцааг тогтоох асуудлын хүрээнд Шүүхийн тухай багц хууль хэрэгжиж эхэлснээр шүүхийн тогтолцоонд хийсэн шинэчлэлийн нөлөөгөөр шүүх байгууллагад хандаж буй иргэнд үүсэх ачаалалд буюу зардалд өөрчлөлт орсон эсэхийг тодорхойлно. Хэрэв цаг хугацааны болон зардлын хувьд өөрчлөлт орсон бол энэхүү өөрчлөлт нь эерэг эсхүл сөрөг үр дагавар бий болгосныг тогтоохыг зорих бөгөөд дээр дурдсан социологийн буюу анкетын судалгааны арга болон харьцуулалтын аргыг ашиглан цуглуулсан мэдээлэлд суурилсан судлаачийн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. Тус зөвлөмжид хууль хэрэгжихээс өмнө гарч байсан зардал, одоо гарч байгаа зардлыг харьцуулан судалсны үндсэн дээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгана.

3. ХЗДХЯ-ны ТНБД-ын 2010 оны 99 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-ыг ашиглан хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг, зардлын хамт тооцно.
4. Харьцуулалтын аргаар 2013 оны 4 дүгээс сараас өмнө болон хойш шүүхийн тогтолцоотой холбоотой үүссэн баримт бичиг, мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, харьцуулалт хийнэ.

Хамрах хүрээ, түүвэрлэлт

Судалгаанд шүүх байгууллагаар үйлчлүүлэгч иргэн, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан болон өмгөөлөгч, прокурор, цагдаагийн албан хаагч нарын төлөөллийг санамсаргүй түүвэрлэлтийн арга техникээр хамруулсныг судалгаанд хэрэглэсэн арга тус бүрээр нь дараах түүвэрлэлтийн хүснэгтэд үзүүлэв. (Хүснэгт 1.1).

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан шүүх, байршил, төрлөөр

№	Шүүхийн дугаар	Байрлал	Төрөл
	Сум дундын 23 дугаар шүүх	Төв аймаг Зуунмод сум	Иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
	Сум дундын 21 дүгээр шүүх	Сэлэнгэ аймаг Мандал сум	Иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
	Дүүргийн 4 дүгээр шүүх	Улаанбаатар хот Налайх дүүрэг	Иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүх

Судалгааны ажлыг гүйцэтгэх хугацаанд Дүүргийн иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх болон уг шүүхээр үйлчлүүлж буй иргэдээс судалгаа авахыг зорьсон боловч давж заалдах шатны шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж буй иргэд өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцоогүй, өмнө нь оролцож байсан иргэдээс судалгаа авах боломж бүрдээгүй тул давж заалдаж буй иргэдээс судалгааны асуудлын хүрээнд мэдээлэл цуглуулах ажил амжилт олсонгүй. Харин орон нутагт ажиллаж байх хугацаанд Дархан-Уул аймгийн Дархан хот, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум дахь давж заалдах шатны шүүхээр үйлчлүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл болон зарим сайжирсан асуудлын талаарх иргэдийн санал бодлыг хуваалцах боломж гарсан юм.

Анкет буюу санал асуулгын түүврийн хэмжээ: Шүүх байгууллагаар үйлчлүүлсэн иргэнээс мэдээлэл цуглуулах анкетын асуулгад нийт

78 иргэнийг хамруулсан. Судалгаанд шүүхээр үйлчлүүлсэн болон үйлчлүүлж буй 150 иргэнийг хамруулахаар төлөвлөсөн ч орон нутагт ажиллах үеэр шүүхээр үйлчлүүлсэн иргэд судалгаанд оролцохоос татгалзах, тодорхой мэдээлэл өгөхөөс зайлсхийх болон шүүх байгууллагаар үйлчлүүлж буй иргэд төвөөс зайдуу амьдардаг зэрэг бэрхшээл тулгарснаар судалгааны багийн зүгээс түүврийн хэмжээг бууруулахад хүрсэн.

Хүснэгт 1.2: Анкетын аргаар цуглуулсан мэдээллийн түүврийн хэмжээ

	Түүврийн хэмжээ
Шүүх байгууллагаар үйлчлүүлсэн иргэнээс мэдээлэл цуглуулах анкет	78
Эрдэнэсант	18
Дэлгэрхаан	4
Жаргалант	12
Цээл	16
Зуунмод	12
Налайх	8

Ганцаарчилсан ярилцлага хийгдсэн тоо: Урьдчилан бэлтгэсэн ярилцлагын асуулгаар нийт 29 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж (хүснэгт 1.3) анкетын судалгаагаар олж авсан мэдээллийг гүнзгийрүүлсэн, тодруулсан мэдээллүүдийг цуглуулсан.

Хүснэгт 1.3: Ганцаарчилсан ярилцлага хийсэн тоо

Ярилцлага хийх субъект	Ярилцлагын тоо	Оролцогчдын байршил
Шүүгч, шүүхийн захиргааны ажилтан	5	Төв аймаг
	3	Сэлэнгэ аймаг
	4	Налайх дүүрэг
Өмгөөлөгч	5	Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Налайх дүүрэг
Сумын хэсгийн төлөөлөгч	3	Төв аймаг
Сумын засаг дарга	1	Төв аймаг
Цагдаа	3	Төв аймаг, Сэлэнгэ аймаг
Прокурор	2	Төв аймаг, Сэлэнгэ аймаг
Иргэд	3	Төв аймаг
Нийт:	29	

Судалгааны ажлын хугацаа, багийн удирдлага зохион байгуулалт

Тус судалгааг ННФ-ын “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүхийн шинэтгэлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны хооронд Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилттэйгээр социологич, судлаач Б.Доржпагма, эдийн засагч, судлаач Ж.Ариунцэцэг, зөвлөх судлаач хууль зүйн ухааны магистр Ж.Бариширсүрэн нар хийж гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. Монгол Улсын шүүхийн тойргийн тогтолцоог өмнөх тогтолцоотой харьцуулсан байдал

*“Засаглалын эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх,
шүүх эрх мэдэлд хуваарилж, тэнцвэржүүлэх нь хүний эрх,
эрх чөлөөг бодитой хангах болон хамгаалах чухал нөхцөл”*

Ш.Л.Монтескье

Аливаа улс орны засаглалын төрлөөс хамааран тухайн орны шүүх Эрх мэдлийн хэмжээ тодорхойлогдож байдаг. Төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлэн хуваарилах нь аль нэг байгууллага дээр хэт их эрх мэдэл төвлөрүүлэхгүй байх, эрх мэдлийг хяналтгүйгээр хэтрүүлэн ашиглахаас сэргийлж буй явдал юм. Засаглалын үндсэн 3 баганын нэг болох “шүүх эрх мэдэл” гэсэн цогц ойлголтод шүүх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалтын үндэс, бүрэн эрх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим, боломж, шүүгч нарын эрх зүйн байдал багтдаг⁵. Энэ хэсэгт Монгол Улс дахь шүүх эрх мэдлийн нэгээхэн хэсэг болох шүүхийн тогтолцооны түүхэн хөгжлийг тоймлон харуулахыг хичээсэн юм.

1.1. Монгол улсын шүүхийн тогтолцоо I

Монгол Улсад 1921 оны хувьсгалаас өмнө үндсэндээ шүүх засаглал гүйцэтгэх засаглалаас ангид болоогүй байсан гэж үздэг. Бие даасан шүүх байгууллага нь анх 1925 онд Улсын 2 дугаар Их Хурлаас баталсан

⁵ “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо” С.Жанцан. УБ хот. 2005 он. 8-р тал

тогтоол, дүрмийн дагуу 1926-1927 оны заагаар байгуулагдан Шүүх явдлын яамны шууд удирдлага дор үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна⁶.

Монгол Улс (цаашид МУ гэх)-ын 1924 оны анхны Үндсэн хуульд шүүхийн тухай заалт байдаггүй нь тухайн үед шүүн таслах үйл ажиллагааг Ардын засгийн шүүх явдлын яам, 1923 оноос хошуудын Тамгын газрын зарга шийтгэх хэлтэс эрхэлж байсантай холбон ойлгож болно⁷. Харин 1940, 1960 оны Үндсэн хуулиудад “БНМАУ-д шүүн таслах ажлыг шүүх хэрэгжүүлнэ” хэмээн шүүх байгууллагын талаар зохицуулалт оруулж, баталгаа гаргасан дэвшилт гарсан боловч энэ нь зөвхөн “лоозогносон” зарчим байсан тухай эрх зүй, түүх судлаач эрдэмтэд бичсэн байх нь олонтаа. Үнэндээ бодит байдал дээр шүүх нам засгаас хараат бус, бие даасан хэлбэрт шилжиж чадаагүй бөгөөд шүүх байгууллага ардчилсан тогтолцоонд шилжихээс өмнө буюу 1992 он хүртэл парламент, нутгийн Хурлаас сонгогдож, тэдэнд тайлагнадаг, нэг нам, түүний удирдсан төр засгийн үзэл баримтлалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг, засаг төрөөс хараат байж, тэдний эрх ашгийн өмнөөс шүүн таслах ажиллагаа явуулдаг байсан⁸ нь хэн бүхэнд тодорхой билээ.

Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал нь шүүхийн тогтолцоо, юуны өмнө түүний бүрэлдэхүүн хэсэг болох шүүгчийн хараат бус байдал, бүтцийн нэгж болох шүүхүүдийн хараат бус байдал, үйл ажиллагаандаа баримталж буй үндсэн зарчим, тэдгээрийг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог. Социалист нийгмийн үеийн шүүхийн тогтолцоо нь 70 гаруй жилийн турш нэгдмэл “босоо” тогтолцоотой байж бүхэлдээ нам, төр засгийн нөлөөнд ажиллаж байсан юм. Харин 1992 оны шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг засаглалын бие даасан салаа болгон аливаа нам, төрийн хараат байдлаас гаргах үзэл баримтлалыг иш үндэс болгосон нь шүүхийн шинэтгэлийн гол цөм нь болсон гэж үзэж болох юм. Үндсэн хуулийн “Төрийн байгуулал”⁹, “Үндсэн хуулийн цэц”¹⁰ болон холбогдох бусад зүйл, хэсэгт шүүх эрх мэдэл болон түүний үндсэн нэгж болох шүүгч

⁶ “Шүүх эрх мэдлийн шинэтгэл сэдэвт онол, практикийн бага хурлын эмхэтгэл” 2012 он. УБ хот.

⁷ Мөн тэнд.

⁸ Мөн тэнд.

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн Дөрөв буюу “Шүүх эрх мэдэл” хэсгийн 47-55 дугаар зүйлд шүүх эрх мэдлийг хэрхэн хэрэгжүүлэх, шүүхийн үндсэн тогтолцоо, шүүхийн захиргаа зэрэг асуудлыг зохицуулдаг. Судалгааны ажлын хүрээний асуудал болох шүүхийн тогтолцоог 48.1 зүйлээр тодорхойлсон байна.

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар бүлэгт “Үндсэн хуулийн цэц”-тэй холбоотой үндсэн асуудлыг тодорхойлж өгсөн байдаг.

хараат бус, бие даасан байх зайлшгүй шаардлагыг удирдлага болгон түүнийг хангаж ажиллах эрх зүйн үндэслэлийг тодорхойлж өгснөөр шүүх байгууллага төрийн эрх мэдлийн гурван үндсэн тулгуур багана / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх/- ын нэг байх нөхцөл зарчмын хувьд бүрэлдсэн. Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн шүүхийг аль нэг төрийн байгууллагаас шууд хараат байдлыг таслан зогсоож зөвхөн Үндсэн хууль болон түүнд нийцсэн, албан ёсоор нийтлэгдсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэн шийдвэр гаргадаг буюу гагцхүү хуульд захирагддаг шүүх болгох ажлыг эхлүүлсэн нь шүүхийн шинэтгэлийн “шүүх, шүүгч зөвхөн хуульд захирагдана” гэсэн үндсэн зорилгод нийцсэн хэрэг болсон.

Монгол Улсын шүүхийн тогтолцоо үндсэн, дагнасан болон төрөлжсөн шүүхээс бүрдэх бөгөөд харин ямар нэг тусгай шүүх байгуулахыг хориглохоор тодорхойлсон байдаг¹¹. Гэвч түүхэн хөгжлийн явцад шүүхийн тогтолцоонд цөөнгүй өөрчлөлт орж байсан бөгөөд 70 гаруй жилийн турш ямар нэгэн байдлаар тусгай шүүх байгуулж хэрэг маргааныг шүүхээс гадуур, хөндлөнгийн нөлөөтэйгөөр шийдэж байсан гашуун туршлага олон бий¹².

1.2. Монгол Улсын шүүхийн тогтолцоо II

1980 оны эцсээр социалист орнуудад гарсан эрх чөлөөний төлөөх хөдөлгөөнүүд эрх мэдлийн нэгдмэл тогтолцоо, нэг намын удирдлага, хараат байдлаас татгалзаж хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд шилжих хөдөлгөөнийг эрчимтэй өрнүүлсний үр дүнд социалист нийгмийн тогтолцооны “эцэг” Зөвлөлт Холбоот Улс задарч, шинээр тусгаар тогтнолоо зарласан орнууд болон постсоциалист орнууд түүний дунд МУ-ын хувьд ч мөн адил улс төр, нийгмийн шинэчлэл хийх буюу хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зарчимд тулгуурласан иргэний ардчилсан нийгмийг цогцлоох боломж нээгдсэн юм.

Ардчилсан хөдөлгөөн ялалт байгуулсны дараа 1990 оны 4 дүгээр сард БНМАУ-ын Үндсэн хуульд томоохон өөрчлөлт орсноор МУ-ын шүүх, шүүхийн тогтолцоо, үйл ажиллагаа зарчмын хувьд өөрчлөгдсөн¹³. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулиар Монгол Улсын төрийн

¹¹ “Шүүх эрх мэдлийн шинэтгэл” сэдэвт онол, практикийн бага хурлын эмхэтгэл. 2012 он. УБ. 20-р тал

¹² Хавсралт № 1. Монгол Улсын шүүхийн шинэтгэлүүд буюу шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтүүд

¹³ “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо” С.Жанцан. УБ хот. 2005 он. 63-р тал

байгууллыг “төрийн эрх мэдлийг хуваарилах” онол, зарчмыг баримтлан тодорхойлсон нь шүүх бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулахад чухал нөлөө үзүүлсэн.

Үндсэн хуулийн үзэл баримтлал, шаардлагад нийцүүлэн шүүхийн тогтолцоог шинэчлэн байгуулах ажил 1993 онд батлагдсан “Шүүхийн тухай хууль”-аар эхэлсэн гэж үзэж болох юм. Шүүх, шүүгч эрх зүйт төрийн нөхцөлд хараат бус, бие даасан байж, зөвхөн хуульд захирагдах, хуулийн өмнө хэн бүхэн тэгш байх зэрэг үндсэн зарчмуудыг баримтлан ажиллахаас гадна шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх болсон нь шүүхийн шинэтгэлийг зайлшгүй эхлүүлэх шаардлагатай болсон юм. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд зайлшгүй хийгдэх ажлын нэг нь шүүхийн шинэтгэл гэдэгтэй хүн бүр санал нийлж байсан хэдий ч удаан хугацааны турш энэ тухай зөвхөн хэлэлцэж, мэтгэлцэхээс өөр дорвитой ажил хийгдээгүй гэж үзэж болно.

Хүний эрх, эрх чөлөө, эдийн засаг, төрийн байгуулалт, нийгмийн салбарын харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомж боловсруулах зорилгоор УИХ-ын 1998 оны тогтоолоор “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “МУ-ын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан байдаг. Харин шүүх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, хөтөлбөрийг шинэчлэх ажил 2000 оноос эхлэлтэй.

2000 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс /цаашид ШЕЗ гэх/ шүүх хараат бус, хариуцлага хүлээдэг, мэдрэмжтэй, шударга, хүртээмжтэй, бүтээмжтэй байх гэсэн 6 үнэлэмжид суурилсан “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г¹⁴ боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн баталсан нь шүүхийн шинэтгэлийн явцад шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах зарчмыг тодорхойлсон чухал арга хэмжээ болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14/ дэх хэсэгт “... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, ...эрхтэй...” гэж заасан нь иргэн бүрт

¹⁴ УИХ-ын 2000 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 39 дүгээр тогтоол

шүүх байгууллагаар дамжуулан эрх ашгаа хамгаалуулах, хөндөгдсөн эрхээ сэргээлгэх эрхийг олгосноос гадна шүүхийн шийдвэртэй санал нийлээгүй тохиолдолд шат шатны шүүхэд давж заалдах буюу дээд шатны шүүхэд хандах эрх олгож байгаа бол мөн хуулийн 48.1-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэж заасан нь МУ-д хэрэг маргааны төрлөөр дагнасан шүүх байгуулах эрх зүйн үндэс болж байна.

Мөн ҮХ-ийн 48.2-т “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно”, 47.3-т “Шүүхийг зөвхөн Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу байгуулна” гэж заасан байх бөгөөд анх 1993 онд УИХ - аас баталсан “Шүүх байгуулах тухай хууль”- ийн дагуу давж заалдах шатны 21 шүүх, сум буюу сум дундын 27 шүүх, дүүргийн 8 шүүх шүүн таслах үйл ажиллагаа явуулж байсан. Шүүхийн шинэчлэл яригдаж бас явагдаж буй 10 гаруй жилийн дотор “гар хүрдэггүй хууль” гэж удаан шүүмжлэгдэж ирсэн энэ хуулийг Шүүхийн шинэтгэлийн багц хуулийн хүрээнд 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр шинэчлэн баталсан. Уг хуульд шүүхийн бие даасан байдал, зохистой ачааллыг бий болгох, ил тод нээлттэй байх зарчмыг¹⁵ баталгаажуулах болон шүүхийн дотоод хараат бус байдлыг бууруулах шинэчлэлийн зохицуулалт багтжээ. Мөн шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулахын тулд түүний эдийн засаг, улс төр, эрх зүй, аюулгүй байдал, зохион байгуулалтын чиглэлийн цогц баталгааг тусгаснаараа онцлог хууль болсон юм. Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх¹⁶, аймаг, нийслэлийн шүүх¹⁷, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс¹⁸ бүрдэх бөгөөд ердийн болон дагнасан төрөлтэй буюу шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно” гэж зохицуулсан нь ҮХ-ийн дээр дурдсан заалтуудыг улам нарийвчилж өгсөн юм¹⁹. Дээрх эрх зүйн актуудын дагуу давж заалдах шатны 18

¹⁵ Шүүхийн тухай шинэ хуулиар шүүхийн шийдвэрийг тухайн шүүхийн цахим хуудсанд болон Монгол Улсын шүүхийн цахим сан, <http://shuukh.mn/> цахим хуудсанд ил тод байрлуулж олон нийтэд нээлттэй болгосон

¹⁶ Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Улсын дээд шүүх.

¹⁷ Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх.

¹⁸ Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйл. Анхан шатны шүүх.

¹⁹ Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Шүүхийн тогтолцоо

10.1. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг,

шүүх болон сум дундын 29, Захиргааны хэргийн анхан шатны 22, дүүргийн эрүүгийн 4, иргэний 4 нийт 59 шүүх тойргийн зарчмаар байгуулагдан ажиллаж байна.

Ийнхүү шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан явдал нь онолын болон практикийн хувьд багагүй маргаан үүсгэсээр байна. Практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар судалгааны ажлыг дараагийн бүлгүүдэд авч үзнэ. Харин онолын тал дээр үүсээд буй асуудлыг энд цухас хөндье. ҮХ-ийн 48.1-д МУ дахь шүүхийн үндсэн тогтолцоог нутаг дэвсгэрийн буюу засаг захиргааны нэгжид хамаатуулан зохицуулсан нь өөрөө асуудлын эх сурвалж нь болж байгаа юм. Хууль тайлбарлах ажил харьцангуй дор хөгжсөн, хуулийн нэр томъёог нэг мөр болгох ажил хоцорч яваа манай улсын хувьд дээр дурдсан ҮХ-ийн заалтыг өөр өөрийн үзэл бодол, ойлголтоор тайлбарлаж байна. Тухайлбал Шүүхийн ерөнхий зөвлөлөөс УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд албан бичгээр²⁰ “Шүүхийн үндсэн тогтолцоо”-ны талаар тайлбар хүргүүлсэн байдаг. Үүнд: *“МУ-ын шүүхийн тогтолцоо нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахын тулд шүүхүүдийг анхан, давж заалдах, хяналтын гэсэн гурван шатлалд зохион байгуулсан байгууламж юм. Тийм ч учраас “МУ-ын ҮХ-ийн тайлбар” бүтээлд МУ-ын шүүх нь а/ анхан шатны, б/давж заалдах, в/хяналтын шатны гэсэн гурван шаттай тогтолцооноос бүрдэнэ” гэжээ. МУ-ын ҮХ-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол улс шүүхийн үндсэн ба дагнасан гэсэн 2 төрлийн тогтолцоотой байх бөгөөд тэдгээр нь анхан болон давж заалдах, хяналтын гэсэн шатлалаар хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Энэ бол манай шүүхийн тогтолцооны үндсэн мөн чанар юм. ... Харин засаг захиргаа, нутаг дэвсгэрийн ямар нэгжид шүүх байгуулах нь шүүхийн харьяалал, хүртээмжийн асуудал юм”* гэсэн нь шүүхийн тогтолцоо болон шүүхийн харьяаллын асуудал нь бие биеэсээ ангид ойлголт бөгөөд тогтолцооны болон харьяаллын асуудлыг салгаж ойлгох, хэрэглэх шаардлагатай бөгөөд ҮХ-ийг “утгачлан ойлгох” тухай тайлбарлаж байна. Харин шүүхийн тогтолцоонд хийгдсэн өөрчлөлт ҮХ зөрчиж байна гэж үзэж буй талаас гаргасан тайлбартаа *“Үндсэн хуулийн зүйл, заалтыг тайлбарлах үйл ажиллагаа бол түүний эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж, таниулах үйл ажиллагаа буюу*

нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.

10.2. Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна.

²⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/2009 тоот албан бичгийн хавсралт. Цахим хуудас: <http://www.judcouncil.mn/main/1008--.html>

түүний бичвэрт орсон утгыг ямар нэгэн хоёрдмол утга санаагүйгээр, өөрөөр хэлбэл хуульч биш энгийн иргэнд ойлгогдож байхаар түүнийг тайлбарлах үйл ажиллагаа хэмээн тодорхойлдог” тухай дурдаад, үүнийг үндэслэн “ҮХ-ийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт тайлбар хийж үзвэл: Нэгдүгээрт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх²¹” ёстой хэмээн үзэж байна.

Дээрхээс харахад ҮХ-ийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлээр зохицуулж буй асуудлыг хэрхэн нэг мөр ойлгох тухай тайлбар гаргах зайлшгүй шаардлага гарч байгааг илэрхийлж байна. Тухайлбал хуулийн дээрх заалтуудад “хотын шүүх” гэсэн хэсэг байхгүй, гэтэл сүүлийн үед Налайх, Багануур зэрэг дүүргүүдийг хотын статустай болгох, хот болгож бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Иймд хот болж тэлсэн дүүргүүдийн хувьд шүүхтэй байх эсэх нь мөн л ҮХ зөрчих, маргаан дагуулах боломж бүрдүүлж байгаа харагдаж байна.

1.3 Шүүхийн тогтолцооны шинэчлэлийн үр нөлөө, тулгамдаж буй асуудал

Иргэдийн хандлага, байр суурь

Хууль санаачлагчийн зүгээс шүүхийг тойргийн тогтолцоонд шилжүүлэх үндсэн шаардлага нь “Шүүхийн ажлын ачаалал хот суурин газар, хөдөө орон нутагт харилцан адилгүй байдгаас эдийн засгийн үр ашгийн хувьд учир дутагдалтай байна. Түүнчлэн, шүүхийн тогтолцоо нь орон нутгийн засаг захиргаанд тулгуурласнаар тухайн засаг захиргааны хөндлөнгийн нөлөөлөл бий болгож байна.” гэдгээс урган гарч байгаа тул “Энэхүү асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүхийн тогтолцоог нутаг дэвсгэрийн байршил, хүн амын нягтаршил, хэрэг, маргааны шийдвэрлэлтийн тоо зэргийг харгалзан тойргийн журмаар байгуулах нь зүйтэй²²” гэж үзсэн байдаг.

Энэ зорилго нь шүүх байгууллагын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гаргаж буй шийдвэрийн чанарыг сайжруулахын зэрэгцээ шүүхийн

²¹ Цахим хуудас: <http://www.legalinfo.mn/law/details/10782>

²² “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн танилцуулга” <http://www.forum.mn/projects/Shuuhiiin%20haraat%20bus%20baidal/Introduction%20of%20draft%20laws%20on%20judiciary.pdf> цахим хуудаснаас үзнэ үү

үйлчилгээг иргэдэд ойртуулах, хурдан шуурхай болгоход чиглэсэн гэж үзэж болох юм. Бодит нөхцөл дээр хууль санаачлагчийн энэхүү хүсэл зорилго өнгөрсөн 2 жилийн хугацаанд багагүй маргаан, хүндрэл дагуулсныг судалгаагаар тогтоосон. Судалгааны баг шүүхийн тогтолцооны шинэчлэлийн үр нөлөөг судлах шинжилгээний ажлаар орон нутагт ажиллаж байх хугацаанд нутгийн иргэдээс гадна шүүхийн захиргааны ажилтнууд хүртэл шүүхийн харьяаллыг хэрхэн тогтоосныг ойлгохгүй байгаагаа илэрхийлж байсан юм. Судалгаанд оролцогчдын зүгээс тойргийн шүүхийн харьяаллыг тогтоохдоо ямар ч судалгаа, шинжилгээ, санал асуулга, хэлэлцүүлэг хийгдээгүй, хэрэв судалгаа хийгдсэн бол “*тэр судалгааг лав хүнээс аваагүй*” гэх шүүмжлэл их байлаа. Тухайлбал, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сумд Багануур, бусад зэргэлдээ орших 3 сум Налайх орж шүүхэд хандаж байхад тэдний дунд орших Архуст сум яагаад ганцаараа “цойлон” Зуунмод сум орж байгааг, мөн аймгийн төвөөс 270 орчим км зайд орших Дэлгэрхаан сумынхан Зуунмод орж байхад түүний зэргэлдээ сум Эрдэнэсант аймгийн төвөөс 240 гаруй км зайд байж яагаад Хархорин орохоор зохицуулагдсан учрыг олохгүй байгаагаа илэрхийлж байсан юм.

Кейс №1:

Эрүүгийн хэргийн гэрчээр шүүх, цагдаад дуудагдаад жил орчим болж байна. Өнгөрсөн хугацаанд олон удаа дуудагдлаа, их хэцүү. Анх шүүхэд дуудагдсаныхаа дараа л Хархорины шүүхэд харьяалагдаж байгаагаа мэдсэн. Өмнө нь Зуунмодод очдог байсан нь илүү амар байсан. Эндээс 10,000 төгрөгөөр хот хоорондын унаанд суугаад хот ордог, хотоос 2,000 төгрөгөөр аймаг ордог. Аймаг орох шаардлага хүн бүхэнд байна. Очоод ажлаа бүтээхээс гадна амьтан ах дүүтэйгээ уулзах, буцахдаа хотоос хэрэгтэй зүйлээ худалдаж авах гээд хэд хэдэн ажил амжуулаад ирдэг байсан бол одоо Өвөрхангайд хүн танихгүй, очих айлгүй болохоор гудамжинд суугаад л шүүгч, цагдаа нь хэзээ дуудахыг хүлээгээд суух нь үнэхээр хүнд байна. Хөдөөний бид мөнгө төгрөг муутай. Танилгүй газар чинь аяга цай хүртэл мөнгөөр авдаг. Хоол, буудал гэвэл бүр ч барахгүй. Гэхдээ гэрээсээ авч явсан хүнс дуусвал хоол авч идэхээс яахав. Хоолны зардлаас илүү замын зардал их хүндрэлтэй. Манай эндээс Хархорин явдаг унаа байхгүй. Шүүх явах гээд унаа хайна, хамт яваад зардал хуваалцах хүн хайна. Бөөн ажил. Хүмүүст тийшээ явах шаардлага ер алга. Ганцаараа явахаар шатахууны зардал талдаа 20 гаруй мянга болно, дээрээс нь жолоочдоо жаал жуул юм өгнө. Сүүлдээ бүр цагаандаа гарсан. Мөнгөгүй үедээ мөрдөн байцаагчийнхаа унаанд дайгдах болсон. Ингээд бодохоор шүүх хэдий ойртсон ч гэлээ хүрч очиход улам хэцүү болсон. Шүүх шилжсэнээр иргэнээс гарах зардал ер нь хамгийн багадаа 2 дахин их болсон.

Шүүхийн харьяалал өөрчлөгдсөн тухай болон бусад ийм төрлийн мэдээлэл бидэнд ирдэггүй, ер нь сонгуулийн үеэр л энэ хавиар хүн амьтан бужигнаж, янз бүрийн мэдээлэл өгдөг. Түүнээс биш ийм хүнд хэрэгтэй, мэдэж баймаар мэдээлэл өгөх гэж ийшээ зорьж ирдэг хүнгүй болоод удаж байна. Шүүхийн шинэчлэлийн талаар мэдээлэл бараг байхгүй. Хааяа зурагтаар л ярьж байгааг дутуу дульмагхан сонсох юм.

Эрдэнэсант сумын иргэн Б

Дээрх кэйсээс харвал тойргийн шүүх байгуулж сумдыг хуваарилахдаа орон нутгийн зам харгуй, дэд бүтэц болон нийтийн тээврийн чиглэл, хүртээмжийг огт анхаараагүйн улмаас “*жимгүй газар жим гаргуулж байгаа нь*” иргэдийг ихэд чирэгдүүлж, хүндрүүлж байна. Шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс энэ төрлийн шүүмжлэл их гарч байв.

Шигтгээ №1.

Шүүхийн тогтолцоо өөрчилсөн шийдвэрийг иргэдэд маш их ачаалал нэмсэн шийдвэр гэж хэлж болно. Бусад өмгөөлөгч нар ч гэсэн ер нь санал нийлэх байх. Төв аймгийн иргэн хүн Хархорин, Зүүнхараад очиж хэргээ шийдүүлдэг, таньдаг айл байхгүй, буудалд хононо. Гэтэл хүн болгон буудалд хонох амьдралын боломж байхгүй. Энэ бүгдээс болоод зун гадаа хоносон тохиолдол ч гарсан гэж сонссон. Одоо харин харьцангуй байнга шүүхээр ирж очих хэрэгтэй байгаа иргэд тэндээ ганц нэг айлтай танилцдаг, хонодог болсон байна. Үүнээс гадна хоол ундны асуудал байна. Хичнээн таньдаг айлтай, тэндээ хоолоо ч өдөр нь хоолны газар орж хооллох хэрэгтэй болдог. Зуунмодод бол ихэнхийнх нь төрөл садан хүмүүс байдаг болохоор ийм асуудал гардаггүй. Энд хонохгүй байлаа ч хот ороод хамаатан садныхаа айлд хоночихдог байсан. Мөн өмгөөлөгчид тэнд очиж шүүх хуралд орж байна. Бас л зардал мөнгөний асуудал гардаг.

Өмгөөлөгч

Шигтгээ №2.

Шүүхийн тогтолцоо ... өөрчлөгдсөнд нэг сөрөг тал байгаа нь нутаг дэвсгэрийн харъяаллын хувьд иргэдэд их чирэгдэл учруулж байгаа. Иргэд дасаагүй учраас чирэгдэлтэй юм шиг байдал харагдаад байна. Засаг захиргааны зохион байгуулалтын хувьд өөрчлөлт ороод харъяаллыг нь өөрчлөөд нэг болгочихоогүй тохиолдолд нутгийн иргэд хоёрдмол ойлголттой болчихож байгаа юм. Орон зайны хувьд арай ойртож өгсөн..

Өмгөөлөгч

Дээрх жишээнээс харахад шүүхийн харьяалалд өөрчлөлт орсон явдал нь нэг талдаа Төв аймгийн захын сумд болох Эрдэнэсант, Борнуур, Сүмбэр, Батсүмбэр, Жаргалант сумын иргэдэд хүндрэл учруулж байх магадлал өндөр байгаа бол нөгөө талдаа төвийн сумд буюу Налайх, Багануур дүүрэгт харьяалагдаж буй сумын иргэдийн хувьд энэ асуудал харьцангуй чирэгдэлгүй байгааг харуулж байна. ДИХАШ 3,4-р шүүх, ДЭХАШ 3,4-р шүүхэд харьяалуулсан сумд орон нутгийн төв замын дагуу байрладаг, өмнө ч мөн адил Налайхаар дамжин өнгөрч Зуунмод ордог байснаас гадна богино зайд²³ зорчиж байгаа тул зардал багатай буюу өмнөх тогтолцоотой харьцуулахад зардлын хувьд хэмнэх боломжтой, гэвч зарим иргэний хэрэг, маргаан үүссэн үед хэмнэлт гарахгүй байна.

Шигтгээ №3.

Шилжсэн сумын иргэдийн хувьд лавлагаа авах хэргээр зайлшгүй Зуунмод ирэх хэрэгтэй болдог учраас гомдол гаргадаг, яагаад ийм чирэгдэлтэй болчихвоо гэж асуудал тавьдаг байсан бол одоо харьцангуй ойлголттой болсон, ийм гомдол санал тавьдаг иргэд цөөрч байна.

Төв аймгийн шүүгч

Шигтгээ №4.

Иргэний хэргийн хувьд нотлох баримтыг иргэд өөрсдөө цуглуулдаг тэр нь бүгд Төв аймагтаа төвлөрсөн байдаг учраас энэ бол иргэдэд маш хүндрэлтэй. Тухайлбал, Эрдэнэсант сумын иргэн ажилласан жил тогтоолгох хэрэгтэй боллоо, Өвөрхангайд очих хэрэгтэй болно. Гэтэл хэрэгтэй бичиг баримт, лавлагаа нь энд Зуунмодод байдаг. Энэ бол яах аргагүй хүндрэлтэй. Харин энэ мэргэшүүлсэн явдал бол манай шүүхийн тогтолцоонд үгүйлэгдэж байсан зөв зүйтэй алхам яах аргагүй мөн.

Төв аймгийн шүүгч

Шигтгээ №5.

Эхний үед Төв аймгийн зарим иргэн өртөөн дээр хоносон гээд сонсогдож байсан. Одоо бол дасаад иргэд учраа олоод явж байгаа. Мэдээлэл ч сайн болсон, шүүх ч анхаарч ажиллаж байгаа нь харагддаг.

Төв аймгийн өмгөөлөгч

²³ Эрдэнэ сумаас Налайх дүүрэг ороход 47 км замыг ойролцоогоор 50 минутын дотор туулдаг бол Зуунмод хүрэхэд 82 км замыг дунджаар 1 цаг 20 минут туулдаг байна. Эх сурвалж: <https://www.google.mn/maps/dir/Zuunmod,+Tov/Erdene/@47.7303148,107.082615,10z/data=!3m1!4b1!4m13!4m12!1m5!1m1!1s0x5d96a34c4e1e89bf:0x60209626f83b5052!2m2!1d106.9577199!2d47.7008606!1m5!1m1!1s0x5d94439027b-57f71:0xd12ca64d4a2ccd13!2m2!1d107.7981082!2d47.7196841?hl=en>

Үүнээс харахад шүүхийг тойргийн системд оруулснаар бусад хөдөө орон нутгийн зам харгуй, дэд бүтэц хөгжөөгүй, алслагдсан сумдад оршин суугаа иргэд дэд бүтэц, нийтийн тээврийн сүлжээнээс хамааран шүүхээс улам алслагдсан байх магадлалтайг илэрхийлж байгаа бол дэд бүтэц, улсын хэмжээний төмөр зам, авто замын дагуу байрлах сумдын иргэдийн хувьд ачаалал нэмэгдээгүй гэж үзэж болно. Гэхдээ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй иргэдийн тухайд засаг захиргааны нэгжийн харьяалал өөрчлөгдөж байгаагийн улмаас давхар зардал гаргах шаардлага үүсээд байна. Үүний тод жишээ бол “ажилласан жил тогтоолгох”-оор ИХШ-д хандах явдал юм.

Шүүхийн харьяаллыг өөрчилж тойргийн тогтолцоонд шилжүүлсний улмаас шүүхийн шинэ харьяаллын дагуу Зуунмод сумын шүүхээс шилжиж өөр засаг захиргааны нэгжид хамааралтай шүүхэд очиж иргэний хэрэг шийдвэрлүүлж буй тохиолдолд улам их чирэгдэл, хүндрэлтэй болсон талаар иргэд гомдолтой байлаа. Жишээ нь, Мандал сум дахь Сум дундын 21-р шүүхээр энэ төрлийн хэрэг шийдүүлж буй иргэн заавал Зуунмод сум орж лавлагаа авах шаардлага гарч байгаа нь давхар зардал үүсгэж байгаа зэрэг асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Шигтгээ №6.

Анхан шатны шүүхийн шийдвэртэй санал нийлээгүй бол давж заалддаг. Давж заалдах өргөдлөө анхан шатны шүүхдээ гаргадаг. Гэтэл давж заалдсан өргөдөл маш их удаж байж давахын шүүхэд хүрдэг. Яагаад удаад байгаа шалтгааныг нь асуухаар “шуудан дүүрээгүй байна” гэдэг. Ингэснээр иргэн эдийн засаг, цаг хугацаа, сэтгэл санаагаараа хохирч байна. Үүнээс ч болдог юм уу, давж заалдах шатанд шүүх хуралдааны тов хэтэрхий их удаж байж зарлагддаг. Ер нь бол өргөдөл арай гэж хуулийн хугацаандаа очдог. Хугацаа хэтэрсэн гээд хүлээж авалгүй өргөдлийг нь буцаасан тохиолдол ч гарч байсан.

Өмгөөлөгч

Шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтийн үр дагавар, тулгамдаж буй асуудлын хүрээнд дараах товч дүгнэлтэд хүрлээ. Үүнд иргэдээс авсан судалгааны дүнгээс харахад тойргийн шүүх байгуулагдсанаас хойш өнгөрсөн 2 жилийн хугацаанд хууль санаачлагчийн “*шүүхийг иргэдэд ойр сум, дүүрэгт харьяалуулан, тойргийн журмаар байгуулах нь шүүхийн үйлчилгээг иргэдэд аль болох ойртуулах*” гэсэн хуулийн үндсэн зорилгын хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь шинэ тогтолцоонд шилжихээс өмнө иргэдэд хангалттай мэдээлэл өгөөгүй,

шүүхэд хүрэх дэд бүтэц /зам, нийтийн тээвэр/ зэрэг чухал асуудлыг анзааралгүй орхисон нь иргэдэд шүүхийг ойртуулсан бус харин ч зардал, чирэгдэлтэй болгосон байна. Тухайлбал Төв аймгийн Эрдэнэсант сумын иргэд Өвөрхангай аймгийн Хархорин сумын шүүхэд харьяалагдах болсноор зөвхөн өөрийн унаа, хөлсний тэргээр тус шүүхэд хүрдэг болсон нь Зуунмод сум дахь СДШ-д тогтмол цагийн хуваариар зорчдог нийтийн тээврээр хүрэхээс даруй 2-4 дахин их зардал гаргадаг болсон тухай ярьж байсан. Мөн зэргэлдээ орших Дэлгэрхаан сумын иргэд Зуунмод сум хүрэхэд Эрдэнэсант сумаас даруй 50-60 км илүү зам туулдаг хэр нь Зуунмод сум дахь СДШ-д харьяалагдаж байгаа нь шүүхийн тойргийг тогтоохдоо ямар мэдээлэл, судалгаанд суурилсан болох нь ойлгомжгүй байгааг илэрхийлж байна. Мөн зарим иргэний хэрэг маргааныг шийдвэрлүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагааг одоогоор зөвхөн аймгийн төвд байрлах албан байгууллагуудаас авах боломжтой байгаа нь иргэдэд давхар зардал учруулж буй үндсэн шалтгаан болж байна.

Шүүхэд тулгамдаж буй зарим асуудал

Шүүх байгууллага бусад эрх мэдлээс хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулахад эдийн засгийн бие даасан байдал чухал юм. Шүүхийн эдийн засгийн баталгааг хангаснаар шүүхийн үйл ажиллагаа бүрэн гүйцэд, хангалттай, чанартай явагдана. Энэ тухай Нэгдсэн Үндэстний байгууллага /цаашид НҮБ гэх/-ын “Шүүхийн хараат бус байдлын суурь зарчмууд”-ын 7-д “Гишүүн Улсын үүрэг нь шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино” гэж зөвлөсний дагуу МУ-ын Засгийн газар /цаашид ЗГ гэх/ шүүхийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд хангалттай төсөв, санхүүгийн нөөцөөр хангаж өгөх үүрэг хүлээсэн бөгөөд МУ-ын хувьд шүүх байгууллагын санхүүжилтийг төрөөс хангах тухай ҮХ-ийн 48.3, Шүүхийн тухай хуулийн 19.2-т болон “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд тус тус зохицуулсан байдаг. Эдгээр эрх зүйн баримт бичигт тусгагдсан “шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх” зорилт сайн биелэгдэхгүй байна²⁴. Олон улсын хэмжээнд улс, орнууд шүүх эрх мэдэлдээ хэр их төсөв хуваарилдаг, энэ нь тухайн улсын жилийн төсвийн хэдэн хувийг эзэлж байгаа зэрэг шалгуур үзүүлэлтээр тухайн улсын шударга ёсны хэрэгжилтийг хэмждэг байна²⁵.

²⁴ “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл” НФФ. УБ хот. 2010 он. 76-р тал

²⁵ Тухайлбал зарим гадаад орнуудын улсын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувийг харвал Австри 0,8, Турк 1,2, Словак 2, Унгар 3,1, Норвеги 3,2, Хойд Ирланд 5,7 байдаг ажээ. Судалгааны тайлангийн эмхэтгэл. ШЕЗ. УБ хот. 2014 он

МУ дахь шүүхийн шинэчлэлийн хүрээнд ШЕЗ-өөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд шүүх бие даасан, төвлөрсөн төсөвтэй болсноос гадна шүүгчийн цалингийн хэмжээг олон улсын түвшинд ойртуулах зорилгоор нэмэгдүүлснээр өнөөдөр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын албан хаагчдын дунд хамгийн өндөр цалинтай албан тушаал шүүгчийнх болсон юм. 2014 он хүртэл МУ-ын төсөвт шүүхийн төсвийн эзлэх хувийг авч үзвэл²⁶ 1997 онд 0,39 хувь, 2000 онд 0,40 хувь, 2004 онд 0,39 хувь, 2007 онд 0,38 хувь, 2009 онд 0,48 хувь, 2012 онд 0,43 хувь²⁷ -ийг буюу улсын төсвийн дунджаар 0,40 гаруй хувийг эзэлж байсан бол 2014 онд 1,065 хувь²⁸ болж огцом өссөн нь шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн том дэвшилтэт ажлын нэг болсон. Хэдийгээр шүүхийн төсөв нэмэгдэж байгаа ч зарим гадаад орнуудтай харьцуулахад Монгол Улсын шүүхийн төсөв, санхүүжилт хангалтгүй, бага хэвээр байна. Энэ нь шүүхийн үйл ажиллагаа хэвийн явагдахад хүндрэл учруулдаг. Үүнээс гадна шүүхийг тойргийн журмаар байгуулж эхэлснээр шүүхийн төсвийн хуваарилалтад ихээхэн өөрчлөлт орсон нь зарим тохиолдолд хүндрэл үүсэх үндсэн шалтгаан болж байна.

Жишээ болгон авсан Төв аймгийн хувьд 2013 оноос өмнө буюу шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орохоос өмнө нийт 27 сумыг харьяандаа багтаадаг, үүндээ тохирсон төсөвтэй байсан бол шинэчлэлийн үр нөлөөгөөр 10 сум бусад шүүхэд харьяалагдах болсноор тус шүүхийн төсвийг 50 гаруй хувиар бууруулах үндэслэл болсон²⁹. Хэдийгээр шийдвэрлэж буй хэрэг маргааны тоо буурсан, цөөн сум хариуцах болсон, шүүгчийн тоо цөөрсөн ч гэсэн одоогийн шүүхийн тогтолцоонд шилжсэнээр үйл ажиллагааны төсөв танагдаж дараах асуудлууд тулгарч эхэлснийг шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд хэлж байлаа. Үүнд:

1. Шатахууны зардлыг бууруулснаар:

- Нүүдэллэн шүүх хурал хийх боломж багассан. Жилдээ 2-3 удаа сумдад нүүдэллэн шүүх хийх боломжтой төсөв тогтоож өгсөн.

²⁶ Төн тэнд.

²⁷ Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан. Цахим хуудас:

²⁷ https://www.mof.gov.mn/wp-content/uploads/2013/09/Execution_report.pdf

²⁸ Монгол Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 5,594,785.9 сая төгрөгөөр баталж Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргад 59,635.6 төгрөгийг урсгал зардалд зориулан баталсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дээрх урсгал зардал нь 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын 1.06 хувийг эзэлж байна.

²⁹ Төв аймаг дахь Сум дундын 23 дугаар шүүхийн шүүхийн захиргааны ажилтнаас авсан ярилцлагаас

- Шүүх хуралдааны үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах үйл ажиллагаа явагдах боломж хумигдсан. Тухайлбал олон нийтэд нээлттэй шүүх хуралдаан хийхэд цаг хугацаа, зардлын гачигдал гардаг гэх мэт.
2. Шуудан харилцааны зардлыг бууруулснаар хэргийн материал болон “богц”-оо давж заалдах шатны шүүхэд сардаа 1 удаа илгээдэг болсон зэрэг санхүүжилттэй холбогдох хүндрэл гарч байна.

Шүүхийн захиргааны ажилтнаас авсан мэдээллээс харахад Төв аймгийн 10 сум өөр аймгийн шүүхэд харьяалагдах болсноор тухайн шүүхийн төсөв тал хувиар танагдсан гэсэн байр суурьтай байлаа. Харин тухайн шүүхийн 2012-2015 оны төсвийн мэдээллийг харахад /Хавсралт №3/ бензин шатахууны зардал, томилолтын зардал багасаж, бусад зардал өссөн байна. Энэ хоёр зардал нь шүүгч нүүдэллэн шүүх хуралдаан зохион байгуулах, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахад /нээлттэй шүүх хуралдаан зохион байгуулах зэрэг/ зарцуулагдах төсөв юм. Мөн тэдний зүгээс хэргийг давж заалдах шатны шүүхэд хүргүүлэхэд шуудангийн зардал багассанаар тодорхой хугацаанд “богц” илгээдэг болсон нь хэрэг маргааныг хурдан шуурхай шийдвэрлэхэд саад болж байна гэж үзсэн. Тухайлбал анхан шатны шүүхийн шийдвэрийн дараа эрүүгийн хэргийн холбогдогч иргэн давж заалдах шатны шүүх хурал хүртэл хоригдож буй ноцтой асуудлыг өмгөөлөгчдийн нэгэн адил хөндсөн. Үүний шалтгааныг шүүгч нарын зүгээс шуудангийн төсвийг хассантай холбогдуулан тайлбарлаж байсан боловч Төв аймгийн шүүхийн захиргааны төсвөөс харахад шуудан, харилцаа холбоо, интернетийн зардал буураагүй өссөн дүнтэй байлаа.

1.4. Шүүхийн ачаалал, шүүхийн шийдвэрийн чанарт гарсан өөрчлөлт

Шүүх байгуулах тухай хуулийн дагуу Монгол Улсын шүүхүүдийг хэрэг маргааны төрлөөр ангилан шүүхийн бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан явдал нь шүүгчийн орон тоог нэмэх хэрэгцээ шаардлагыг бий болгосон.

Шигтгээ №7.

Мэргэшүүлсэн, дагнасан шүүх байгуулсан нь бол маш зөв алхам болсон. Манай шүүх хэдийгээр дагнаагүй 5 шүүхийн нэг ч гэлээ одоо ажиллаж байгаа шүүгчдийн маань ихэнх нь залуу шүүгч нар байдаг. Тэд нарыг харж байхад ер нь дагнаад ажиллах юмсан, цаашдаа мэргэшиж ажиллах хэрэгтэй байна гэсэн сонирхол ажиглагдаж байдаг. Шүүгчээр олон жил ажилласан хүний хувьд хэлэхэд шүүгчийг нэг чиглэлээр дагнуулж ажиллуулах бол маш зөв юм. Төв аймгаас манай шүүхэд харьяалуулсан сумдын иргэдийн хувьд бол бид нар аль болох чирэгдэл учруулахгүй, онцлогийг нь анхаарч ажиллахыг боддог. Жишээ нь, Батсүмбэрийн иргэд бол өглөөний вагоноор ирээд шууд шүүх хуралд ороод орой буцах боломжтой байдаг болохоор шүүгчийн туслахууд утасдаад өдөр тогтоод, шүүх хурлыг нь хамгийн эхэнд тавих байдлаар зохицуулаад явдаг. Ер нь ямар ч ажлыг сэтгэл гаргаад, шийдэл олоод ажиллаж чадвал сөрөг үр дагаварыг багасгаж болно шүү дээ.

Шүүгч

Мөн УИХ-ын 2013 оны 12 дугаар тогтоолоор³⁰ шүүгчийн орон тоог нэмэгдүүлсэн нь шүүгчийн ачааллыг бууруулах, тодорхой чиглэлээр мэргэшүүлэх замаар иргэдэд үүсэх чирэгдэл /эдийн засаг, цаг хугацаа/-ийг багасгах, үүнээс гадна шүүгчийн ачаалал буурснаар тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд зарцуулах цаг хугацаа нэмэгдэх бөгөөд улмаар шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж эрх зүйн үндэслэл сайтай, тохирох хууль тогтоомжийг бүрэн хэрэглэх нөхцөл бүрэлдүүлэх зорилготой. Энэ зорилгын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд *“шүүхийн тогтолцоонд тойргийн зарчим нэвтрүүлснээр шүүхийн харилцан адилгүй ачааллыг зохистой болгох, засаг захиргааны хөндлөнгийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой. ... Шүүхийг эрүү, иргэн, захиргаа зэрэг хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулснаар шүүгч мэргэшиж, шийдвэрийн чанарт нөлөөлөн улмаар иргэний шударга шүүхээр шийдүүлэх эрхийн нэг үндэс болно.”*³¹³² тайлбарласан байна.

Шүүхийн тогтолцоо өөрчлөгдөн хэрэг, маргааныг дагнасан шүүхээр шийдвэрлэдэг болсон нь шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй ажлуудын дундаас хамгийн ихээр дэмжигдэж буй хэсэг юм. 2012

³⁰

³¹ Хэргийн ачаалал, нутаг дэвсгэрийн ойр дөт байдлыг харгалзан 2-3 аймгийн дунд давж заалдах шатны шүүх байгуулсан. Тойргийн журмаар эрүүгийн давж заалдах шатны 9 шүүх, иргэний давж заалдах шатны шүүх 9 шүүх байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

³² Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн үзэл баримтлал <http://www.forum.mn/projects/Shuuhiiin%20haraat%20bus%20baidal/concept%20paper%20for%20draft%20laws%20on%20judiciary.pdf> цахим хуудаснаас үзнэ үү.

онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага” судалгааны тайланд³³ “иргэний хэрэг хянан шийдвэрлэдэг 1 шүүгч жилд дунджаар 400-аад иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэж байгаа” тухай дурдсан байна.

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нэг шүүгч иргэний болон эрүүгийн хэргийг нэгэн адил шүүдэг, аль ч шүүх бүрэлдэхүүнд ордог байсан зэрэг нь шүүгчийн ажлын ачааллыг үлэмж нэмэгдүүлж байснаас гадна шүүгчдэд тодорхой нэг чиглэлээр мэргэших, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх цаг зав, боломж олгодоггүй байсан нь тэдний гаргаж буй шийдвэрийн чанарт шууд нөлөөлж байсан гэж үздэг. УДШ-ын Судалгааны төвөөс 2012 онд гаргасан улсын хэмжээний статистик мэдээнээс харахад “Ерөнхий харьяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 193, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 338 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна.” гэсэн тоон үзүүлэлт гарсан байдаг³⁴. Харин шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орж хэрэг маргааныг дагнан шийдвэрлэх болсноор шүүгчийн ажлын ачаалал буурч, иргэний эсхүл эрүүгийн чиглэлээр мэргэших, хэргийн материалтай бүрэн танилцаж оновчтой шийдвэр гаргах нөхцөл бүрэлдэж байна гэж үзэж болох юм. Тухайлбал Төв аймгийн Зуунмод сум дахь Сум дундын 23-р шүүхийн нэг шүүгчид 2014 онд 78 хэрэг оногдож байгаа нь шүүгчийн ачаалал эрс буурсныг харуулж байна. Харин хамгийн их хэрэг шийдвэрлэсэн сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 131 хэрэг шийдвэрлэсэн³⁵ байна. Хүн ам нягт суурьшсан хот суурин газар байрлах шүүхийн ачаалал харьцангуй их байна. Тухайлбал ДИХШ-ийн нэг шүүгч дунджаар 267 хэрэг маргаан хянан шийдвэрлэж байгаа бол ДЭХШ-ийн нэг шүүгч дунджаар 58.1 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна³⁶.

³³ “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага” судалгааны тайлан. ХЗҮХ. УБ. 2012 он

³⁴ Эх сурвалж: <http://www.news.mn/content/134242.shtml>

³⁵ ШЕЗ, Монгол улсын Шүүхийн 2014 оны шүүн таслах үйл ажиллагааны нэгдсэн дүн мэдээ (2015)

³⁶ Мөн тэнд

*Хүснэгт 1.4: Төв аймгийн шүүх болон Сум дундын 23-р шүүхээр
шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тоо /2010-2014 он/*

Он	Төв /2013 оны 4 дүгээр сарын 15-аас Сум дундын 23-р шүүх/			Сэлэнгэ / Сум дундын 21-р шүүх/ ³⁷			Өвөрхангай /Сум дундын 18-р шүүх/ ³⁸		
	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа	Эрүү	Иргэн	Захиргаа
2010	170	1404	31	284	1520	21	164	1768	38
2011	213	1494	11	279	1426	8	182	1066	22
2012	245	1423	18	337	1056	33	194	923	22
2013	270	1618	29	292	1156	31	167	1407	27
2014 ³⁹	168	533	24	146	364		60	389	

Дээрх хүснэгтээс харвал шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр Төв аймгийн шүүх нь Сум дундын 23-р шүүх болж шийдвэрлэсэн хэрэг маргааны тоо 2014 онд өмнөх оноос Иргэний хэргийн хувьд 3 дахин, Эрүүгийн хэргийн хувьд 1.6 дахин буурсан байна. Энэ нь Төв аймгийн 10 сум өөр шүүхүүдэд харьяалагдах болж, шүүгч нарын тоог хоёроор цөөлсний дараах үр дүн юм.

Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсон нь нэг талдаа шүүх, шүүгчийн ачаалал буурсан эерэг үзүүлэлт гарч байгаа боловч нөгөө талдаа мөрдөн байцаагч, прокуроруудын ажлын ачаалал нэмэгдүүлсэн сөрөг үр дагавар бий болгосон тухай орон нутгийн судалгааны үеэр ярилцлагын судалгаанд хамрагдсан цагдаа, прокурорууд шүүмжтэй хандаж байсан юм.

Шигтгээ №8.

Иргэдийн зүгээс бол хүндрэлтэй байна гэсэн гомдол, санал бол сонсож байгаагүй. Харин цагдаа, прокурорынхон ажлын ачаалал нэмэгдсэн, өөр аймгийн засаг захиргааны нэгжтэй харьцаж ажиллахад асуудал гардаг гэсэн хандлагатай юм уу гэж ажигласан.

Шүүгч

³⁷ Шүүх байгуулах тухай хуулиар Сэлэнгэ аймгийг Сум дундын 3 шүүхэд хуваасан бөгөөд Сум дундын 21-р шүүхэд Төв аймгийн Сүмбэр, Жаргалант, Борнуур, Батсүмбэр сумдыг харьяалуулсан.

³⁸ Шүүх байгуулах тухай хуулиар Өвөрхангай аймгийг Сум дундын 2 шүүхэд хуваасан бөгөөд Сум дундын 18-р шүүхэд Төв аймгийн Эрдэнэсант сумыг харьяалуулсан.

³⁹ Шүүх байгуулах тухай хуулиар Захиргааны хэргийн анхан шатны 15-р шүүхэд Төв аймгийн нутаг дэвсгэрийн бүх сумд харьяалагдана.

Шигтгээ №9.

Манай ачаалал нэмэгдсэн, үүнийг дагаад 2 мөрдөн байцаагчийн орон тоо нэмэгдсэн байгаа. Гэхдээ зардал нэмэгдсэн, тээврийн зардал хаанаа ч хүрэхгүй байна. Хэрэг гарсан газар очих хэрэгтэй болно, эндээс очиж ажиллана. Гэрч, хохирогч дуудахад хүндрэл учирдаг. Төв аймгийн сумдаас ирэх байнгын унаа байдаггүй, унаа тогтмол биш учраас гэрч, хохирогч цагтаа ирдэггүй. Ер нь шүүхийн тогтолцоонд гарсан энэ өөрчлөлтийг хийхдээ дагалдаж хийх ёстой байсан ажлуудыг тооцоолоогүй, уялдаа холбоог авч үзээгүй нь манай ажлаас бол харагдана.

Мөрдөн байцаагч

Мөрдөн байцаагч, цагдаа нарын ажлын ачаалал нэмэгдсэн асуудал гарсантай шүүхийн захиргааны ажилтнууд, шүүгч санал нэгтэй байсан юм.

Шигтгээ №10.

Миний хувьд хуучин тогтолцоо нь илүү давуу талтай гэж үзэж байгаа. Манай прокурорын хувьд бол Төв аймгаас 4 сум нэмээд орон тооны хувьд нэмсэн боловч зардал нэмж тусгаж өгөөгүй. Гэтэл ачаалал илт нэмэгдсэн, ачааллаа дагаад зардал ч нэмэгдсэн. Иргэдийн хувьд хүндрэлтэй асуудал давж заалдах шатанд яах аргагүй байгаа. Давж заалдах шатны шүүх Дарханд байрлах болсоноор амьдралын боломж хэцүү иргэд бол давж заалдахгүй хаях асуудал байгаа. Энэ бол амьдралд гарцаагүй байна. Шүүхийн тогтолцоонд мэргэшүүлсэн явдал харин дэвшил болж өгсөн.

Прокурор

Шигтгээ №11.

Манай ачаалал бол бараг тал хувиар нэмэгдсэн байгаа. Орон тооны хувьд нэгээр л нэмсэн. Засаг захиргааны харъяалалтай холбоотой асуудал бол гардаг. Тухайлбал, Төв аймгийн нэг сумын цагдаа байна гэж бодоход манай аймгийнх байсан бол бид нар тухайн цагдаагийн ажлын алдаа дутагдлын талаар шууд удирдлагад нь мэдэгдээд, эсвэл зөвлөлдөөд, дэмжлэг аваад явах боломжтой бол Зуунмодод байгаа удирдлагатай бол ийм байдлаар хамтарч ажиллах боломжгүй, албан бичиг явуулдаг, хугацаа алддаг.

Прокурор

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг бусад хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалал, хүний нөөц болон эдийн засгийн байдлыг судалж

үзсэний үндсэн дээр харилцан уялдаатай зохион байгуулах шаардлагатай байгааг дээрх жишээнээс харж болох юм. Тухайлбал цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хил хязгаартай шууд хамааралтай байдаг. Ийм тохиолдолд хэргийн мөрдөн байцаагч үйл ажиллагаа явуулахад харьяаллын асуудал давхар хөндөгдөж байгааг анхаарах шаардлага байна.

1.5 Дэд хэсгийн дүгнэлт

Социалист нийгмийн үеийн шүүхийн тогтолцоо нь 70 гаруй жилийн турш нэгдмэл “босоо” тогтолцоотой байж бүхэлдээ нам, төр засгийн нөлөөнд ажиллаж байсан бөгөөд шүүхийн дарга, шүүгч нарыг төрийн байгууллага, албан тушаалтан сонгон шалгаруулж, томилдог, ажлыг нь тайланд үндэслэн дүгнэдэг байлаа. Шүүгч тогтоол, захирамжаа хуулиас гадна бусад эрх зүйн актад үндэслэн гаргаж байсан зэргээс шалтгаалан шүүх эрх мэдэл засаглалын нэг төрөл бус харин намын үзэл баримтлал, аль нэг байгууллагаас эрх мэдэл, эдийн засгийн хувьд нэгэн адил хараат байсныг илтгэж байна. Харин 1992 оны шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг засаглалын бие даасан салаа болгон аливаа нам, төрийн хараат байдлаас гаргах үзэл баримтлалыг иш үндэс болгосон нь шүүхийн шинэтгэлийн гол цөм нь болж үүнтэй уялдуулан гаргасан хууль тогтоомжоор шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа нь шүүхийн шинэчлэлийн үр дүн, ололттой тал юм.

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд шүүхийн бие даасан байдлыг төсвийн хараат байдлаас ангижруулах, зохистой ачааллыг бий болгох, шүүгчийн орон тоог нэмэгдүүлэх, ил тод нээлттэй байх зарчмыг шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны зарыг олон нийтэд нээлттэй болгох замаар баталгаажуулж байгаа бол хэргийн хөдөлгөөний менежмент, хэргийн хуваарилалтыг өмнө нь ерөнхий шүүгч хуваарилдаг байсныг халж олон улсын жишгээр шинэ програм хангамж⁴⁰ хуваарилдаг болсон зэрэг шүүхийн дотоод хараат байдлыг бууруулах шинэчлэлийн зохицуулалт зэрэг арга хэмжээг тус тус хэрэгжүүлж эхлээд байна. Шүүхийн бие даасан байдлыг

⁴⁰ Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах төслийн хүрээнд хэргийн хуваарилалт, статистик мэдээ, иж бүрэн мэдээллийн сан, боловсронгуй бүртгэлийн болон хайлтын систем бүхий олон улсын жишигт нийцсэн програм хангамжийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлж байна. Жишээлбэл "Иргэн-1", давж заалдах шатанд "Иргэн -2", хяналтын шатанд "Иргэн-3"

баталгаажуулахын тулд эдийн засаг, улс төр, эрх зүй, аюулгүй байдал, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээг тусгасан Шүүхийн тухай хууль нь шинэчлэлийг хурдастах нөлөө бүхий онцлог хууль юм. Хуулийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш багагүй шүүмжлэлд өртөж байгаа боловч хэрэгжүүлж буй ажлууд нь тодорхой үр дүнд хүрч байна. Энэ хуулийн дагуу хэрэгжүүлж буй ажлууд юуны өмнө шүүхийг эрх мэдлийн болон эдийн засгийн хараат байдлаас ангижруулахад чухал алхам болж байна. Үүний тод жишээг шүүх бие даасан, төвлөрсөн төсөвтэй болж төсвөө өөрөө боловсруулдаг, УИХ-д шууд өргөн барьдаг, төсвөө захиран зарцуулах эрхтэй болсон, мөн шүүгчдийн цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаанаас харж болох юм.

МУ-д хүчин төгөлдөр үйлчилж буй бүхий л эрх зүйн акт ҮХ-д нийцсэн байх шаардлага тавигддаг. Одоо мөрдөгдөж буй Шүүх байгуулах тухай хууль энэхүү шаардлагыг хангаж чадаж байгаа эсэх нь маргаантай хэвээр байгаа нь манай улсад хууль тайлбарлах, хуулийг нэг мөр ойлгох чиглэлээр хийгдэж буй ажил, эрдэмтэн судлаачдын бүтээл хомс байгаатай холбоотой. Иймд хууль тогтоомжийн хийдэл, давхардал, зөрчлийг арилгах үүднээс хуулийн тайлбар, нэр томъёоны тайлбаруудыг Улсын дээд шүүх болон бусад холбогдох байгууллагуудаас гаргаж байх хэрэгцээтэй байна.

Шүүхийг тойргийн журмаар байгуулсан явдлыг иргэдийн зүгээс тааламжтайгаар хүлээж авахгүй байгаа нь нэгдүгээрт иргэд шүүхийн шинэтгэлийн талаар мэдээлэлгүй байсан, *хоёрдугаарт* хэдийгээр орон зайн хувьд ойрхон тойргийн шүүхэд харьяалагдсан боловч нийтийн тээвэр, замын нөхцөл муу, энэ төрлийн дэд бүтэц хөгжөөгүй байгаа, *гуравдугаарт* орон нутгийн иргэдэд эдийн засгийн ачаалал үүсгэж байна.

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын дунд шүүхийн шинэчлэлийн дагуу хийгдэж буй өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх, дасан зохицох хандлага өндөр байгаа бол цагдаа, прокурорын байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, багагүй чирэгдэл үүсгэж буй асуудлын нэг болж байна. Шүүхийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг бусад хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалал, хүний нөөц болон эдийн засгийн байдлыг судалж үзсэний үндсэн дээр харилцан уялдаатай зохион байгуулах шаардлагатай байгааг судалгааны дүн илэрхийлж байна.

Судалгааны ажлаас харахад аливаа нэг тогтолцоог өөрчлөх, хууль тогтоомжийг боловсруулах, шинэчлэх ажлын хүрээнд түүний нийгмийн хэрэгцээ шаардлага, зүй тогтлыг тогтоох зорилгоор урьдчилан хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд, ялангуяа өөрчлөлт хийгдэж буй салбар болон тэдэнтэй үйл ажиллагаагаараа уялдаа холбоотой байдаг байгууллагуудын ажилтан, албан хаагч нарт мэдээлэл болгон хүргэх шаардлагыг хангаж ажиллах нь тулгамдаж буй асуудал болж байна. Үүний тод жишээ бол шүүхийг тойргийн журмаар байгуулж, шүүхийн харьяаллыг тогтоохдоо шүүхийн ачаалал, хэрэг маргааны тоо, орон зайн асуудлыг анхаарч, судалгаанд суурилсан шийдвэр гаргасан гэх боловч эдгээр бүтээлүүдтэй танилцах боломж олон нийтэд бүү хэл судлаачдад олдохгүй байгаагаас харж болох юм.

БҮЛЭГ 2. Шүүхийн тогтолцооны өөрчлөлтийн талаарх иргэдийн ойлголт, хандлага

“Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ” судалгааны ажлын хүрээнд Төв аймгийн Дэлгэрхаан, Жаргалант, Цээл, Эрдэнэсант, Борнуур болон Сэлэнгэ аймгийн Мандал сумдаас шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс хойш болон өмнө шүүхээр үйлчлүүлж байсан 150 иргэнээс анкетын аргаар мэдээлэл цуглуулж, шүүхийн захиргааны ажилтан, шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаа зэрэг шүүхийн үйл ажиллагаатай ямар нэгэн байдлаар холбоотой байдаг мэргэжлийн хүмүүсээс ярилцлагын судалгаа авахаар төлөвлөн ажилласан.

Хөдөө орон нутгийн иргэд шүүхийн шинэчлэл болон шүүх тойргийн журмаар ажиллаж эхэлснийг дэмжиж буй эсэх, шинэ тогтолцоонд шилжсэн нь хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэхийг тодруулах зорилготой уг судалгаанд оролцох сонирхолтой иргэд цөөн байлаа. Учир нь иргэдийн дийлэнх нь “шүүх, цагдаатай нэр холбогдсоноо нуун дарагдуулах, энэ тухай хүнд ярихгүй байх нь зөв, болж бүтэхгүй хүн л шүүх, цагдаатай холбогддог” гэсэн ойлголттой хэвээр байгаагаас гадна шүүхийн шинэтгэлийн талаар сонсоогүй, сонссон ч ойлгоогүй иргэн олон байсантай холбоотой. Иймд судалгааны багийн гишүүд судалгаа шинжилгээний ажлын далд үүрэг гэгддэг судалгаанд оролцсон иргэдэд мэдээлэл түгээх үүргийг давхар гүйцэтгэж хууль сурталчлах, тайлбарлах ажлыг хийж байлаа. Үүнээс харахад иргэдийн дунд шүүх, цагдаагийн байгууллагыг үйлчилгээний байгууллага гэхээс илүү “төрийн төмөр нударга” гэж үзэх хандлага давамгайлж байв. Мөн эрх зүйн шинэтгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зөвхөн хот суурин газар явагдаж, хөдөө орон нутгийн иргэд энэ төрлийн мэдээллээс илт хоцордог нь ажиглагдаж байлаа.

Судалгааны ажлын явцад гарсан хүндрэл, бэрхшээлийн нэг нь орон нутгийн хувьд шүүхээр үйлчлүүлсэн Төв аймгийн иргэдийн дийлэнх нь /тариалангийн/ газрын маргаан /малын/, хулгайн хэргээр шүүхэд хандсан байдаг тул сумын төв дээр амьдардаггүй, олж очиж уулзахад бэрхшээлтэй байлаа. Иймээс гол төлөв сумын төв дээр амьдарч буй шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс судалгаа авсан нь анх төлөвлөсөн түүврийн хэмжээнд хүрэхгүй байх гол шалтгаан болсон. Анкетын аргаар авсан санал асуулгад нийт 78 хүнийг хамруулсан ба үүнээс шаардлага хангахгүй, дутуу хариулсан 4 асуулгын хуудсыг хүчингүйд тооцож нийт 74 хүний мэдээлэлд боловсруулалт хийлээ.




График 1: Судалгаанд оролцогчдын гэрийн хаяг

Төв аймгийн харьяалалтай иргэдээс гадна тухайн шүүхүүд дээр үйлчлүүлж буй иргэдээс анкетын судалгааг авахад байнга оршин суудаг байршлын хувьд олон газар байна. Төв аймаг нь Монгол Улсын төвийн бүсийн аймаг бөгөөд нийслэл Улаанбаатар хоттой хамгийн ойр оршдог, бусад аймгуудыг хоттой холбосон улсын хэмжээний олон зам нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрдөг зэрэг нэг төрлийн транзит бүс учир тус аймгийн иргэн биш ч аймгийн нутаг дэвсгэр дээр байхдаа хэрэг маргаанд холбогдон тус аймгийн шүүхэд (хэрэг маргаан гарсан байршлаас хамаарч) хандах хэрэгцээ шаардлагатай тулгарсан явуулын иргэд нэлээдгүй байлаа.

Санал асуулгад оролцогчдын 55,6 хувь нь эрэгтэй, 44,4 хувь нь эмэгтэйчүүд байсан. Насны хувьд залуу, дунд, ахмад насны төлөөлөл жигд хамрагдаж чадсан бол боловсролын хувьд ч жигд тархалттай байлаа. Судалгаанд оролцсон иргэд боловсролын түвшний хувьд 19,4 хувь нь дээд, 25 хувь нь тусгай дунд, 2,8 хувь нь бүрэн дунд, 22,2

хувь нь бүрэн бус дунд, 2,8 хувь нь бага боловсролтой, 2,8 хувь нь боловсролгүй байсан.

Үүнээс харахад шүүхэд хандаж буй иргэдийн нас болон хүйсийн тэгш байдал харьцангуй тэгш байгаа боловч боловсролын түвшний хувьд бүрэн дундаас дээш боловсролын зэрэгтэй иргэд илүү их байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2.1. Шүүхийн тогтолцооны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл

Судалгааны хүрээнд шүүх байгууллагаар үйлчлүүлж буй болон үйлчлүүлсэн иргэдийг хамруулахдаа цаг хугацааны хувьд ямар нэгэн хязгаарлалт тавиагүй юм. Шүүхийн тогтолцоо өөрчлөгдөхөөс өмнө болон дараа шүүхээр үйлчлүүлсэн иргэдийг судалгаанд хамруулахад тэдний 56.7 хувь нь 2013 оноос өмнө шүүхээр үйлчлүүлж байсан бол 24.3 хувь нь 2013 оноос хойш үйлчлүүлсэн байв. /График 2-аас харна уу/




График. 2: 2013 оноос өмнө болон хойно шүүх байгууллагаар үйлчлүүлж байсан эсэх

Шүүхийн тогтолцооны өөрчлөлтийн талаарх судалгаанд оролцсон иргэдийн мэдээллийн түвшинг авч үзвэл шүүхээр үйлчлүүлсэн иргэд шүүхийн шинэтгэл бөгөөд шүүхийн тогтолцооны⁴¹ талаар хангалттай мэдээлэлгүй буюу энэ талаар ямар нэгэн ойлголтгүй байна.

⁴¹ Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх олонх нь “шүүхийн тогтолцоо” гэж юуг хэлдэг тухай тодорхой ойлголтгүй байв. Судалгааны багийн гишүүд зарим иргэдэд шүүхийн тогтолцооны талаар товч танилцуулсны дараа иргэд “учраа ойлгож” санал асуулгад орох, орохгүй тухай шийдээ хэлж байсан юм. Иргэдийн эрх зүйн мэдлэг дорой байгаагаас ярианы хэллэгээр бус албан ёсны нэр томъёо ашигласан тохиолдолд мэдэхгүй, ойлгохгүй байх нь элбэг байна.




График 3: Өмнөх шүүхийн тогтолцооны талаар мэдэх байдал, шүүх байгууллагын тогтолцоо өөрчлөгдсөнийг мэдэх байдал

ШЕЗ цахим хуудсаараа дамжуулан “Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай мэдээллийг Та авч чадаж байна уу?” гэсэн асуулт тавьжээ. Мониторингд оролцсон иргэдийн 58 хувь нь тийм, 42 хувь нь үгүй гэж хариулсан байна. Мөн ШЕЗ-өөс хийсэн “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгаанд шүүхээр үйлчлүүлсэн 2300 хүнийг хамруулсан бөгөөд “Та шүүх болон шүүхийн захиргааны байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ?”⁴² гэсэн асуудлыг оруулсан байна. Тус судалгаанд хамрагдсан иргэдийн 39.7 хувь нь шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хангалтгүй хүрдэг гэж үзсэн нь бидний судалгааны шүүхээр үйлчлүүлсэн ч шүүх тогтолцооны өөрчлөлтийн талаар ямар нэгэн ойлголтгүй гэж хариулсан иргэдийн хувьтай ижил түвшинд байгаа нь иргэдэд хүрч буй мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байгааг илэрхийлж байна. Иймд дээр дурдсан гурван ч судалгааны хүрээнд дэвшүүлэгдэн гарч буй уг асуудалд анхаарал хандуулж иргэдийг шүүх байгууллагын мэдээллээр ханган ажиллах шаардлагатай байна.

Шүүхийн үйлчилгээ бол төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээний нэг төрөл. Шүүхийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хурдан шуурхай, соёлч, баталгаатай байлгах, үүний тулд хараат бус, харилцааны өндөр соёлтой, мэдлэг, ур чадвартай боловсон хүчинтэй байх нь шүүхийн шинэчлэлийн нэг гол зорилго болно. Үүний тулд шүүхийн захиргааны ажилтнууд, шүүгчдийн болон Тахарын албаны ажилтнуудын мэдлэг, харилцааны соёлыг дээшлүүлэх, шүүхийн байранд байршуулсан мэдээ, мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар буюу зарим тохиолдолд энгийн үг хэллэгээр тайлбарлах нь иргэдэд ойртох, чирэгдлийг багасгах нэг хэлбэр болж болох юм.

⁴² Шүүхийн Ерөнхий зөвлөл. Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай мэдээллийг авч чаддаг уу? Мониторингийн дүн. <http://www.judcouncil.mn/main/1586--ye.html>

Иргэд эрх нь зөрчигдсөн тохиолдолд зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд ханддаг билээ. Эрх нь зөрчигдөж эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандсан иргэдийн хувьд шүүхийн байгууллагын талаар хангалттай хэмжээний мэдлэг, мэдээлэлгүй авч чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа нь шүүхээр огт үйлчлүүлээгүй иргэдийн хувьд шүүх байгууллагын талаарх ойлголт, мэдээлэл ямар хэмжээнд буйг давхар илтгэж байна.

Сүүлийн үед төрийн байгууллагууд цахим хуудсаараа дамжуулан мэдээллээ олон нийтэд хүргэж, “*манай байгууллагын үйл ажиллагаа бүх хүнд нээлттэй ил тод болсон/байгаа*” гэж ярьдаг, хэлдэг болсон. Дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, цаг үетэйгээ хамт алхах нь, алхаж буй нь бидний бахархах зүйл яах аргагүй мөн. Гэхдээ хөдөө, орон нутгийн иргэдэд энэхүү үсрэнгүй хөгжлийн үр дүнд бий болсон “цахим хэлбэрээр мэдээллээ тараах” явдал нь нээлттэй, ил тод байдлын шалгуур үзүүлэлт болж чадах эсэх нь эргэлзээтэй асуудал юм. Ялангуяа манай улсын хувьд хүн амын талаас илүү хувь нь төвөөс алслагдмал оршин суудаг малчин өрхүүдтэй, интернэтээс мэдээлэл авах бүү хэл телевиз үзэх цаг завгүй ажилтай айл өрхүүд байдаг. Интернет сүлжээ бүх газруудад байдаггүй, өрхийн оршин суугаа газар, амьжиргааны түвшнээс хамааран компьютер, ухаалаг гар утас айл болгонд байхгүй, байсан ч ашиглах, хэрэглэх чадвар дутмаг байгаа учир иргэдийнхээ амьдралын хэв маяг, нөхцөл байдалд тохируулан мэдээлэл хүргэх арга замыг боловсруулах шаардлагатай нь орон нутагт ажиллах үеэр ажиглагдаж байсан.

Шүүх байгууллага нь иргэн бүрт хамааралтай төрийн институтийн хувьд шүүх байгууллагын талаарх мэдээллийг хэнд? яаж? хүргэж ажиллахаа төлөвлөн, чиглэлээ тодорхойлох нь үр дүнтэй, хэрэгцээтэй, тулгамдсан ажлын нэг болж байгааг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, зөвхөн шүүхээр үйлчлүүлэхээр хандсан иргэдийг мэдээллээр хангах уу? тухайн асуудлыг сонирхсон хүн мэдээллийг олж авдаг байх уу? эсвэл хөдөө орон нутагт байгаа, төвөөс алслагдсан “уулын мухарт малаа хариулаад явж байгаа” иргэнд ч мөн адил мэдээлэл хүргэж ажиллах уу? гэдгээ тодорхойлох шаардлагатай юм. Иргэдийн хувьд эрхээ хамгаалуулах хэрэгцээ шаардлага гарах үеэс шүүх байгууллагын талаар мэдээлэл авах хүсэл эрмэлзэлтэй болдог талаар цөөнгүй судалгаанд дурдсан байдаг.

2.2. Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин

Шүүхээс гарч буй шийдвэр нь хуулийн хүрээнд аль нэг талд шийдвэр гардаг учраас шүүхээр маргаан шийдвэрлүүлсэн хоёр талын аль нэг нь шүүхийн шийдвэрт сэтгэл хангалуун бус үлддэг. Иймд шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход тодорхой арга зүй шаардлагатай бөгөөд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбоотой иргэдийн хандлага, сэтгэл ханамжийн түвшинд тухайн иргэнд холбогдож гарсан шүүхийн шийдвэр зарим талаар нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Судалгааны хүрээнд шүүхийн тогтолцоонд сэтгэл хангалуун байгаа эсэхийг тодорхойлохын тулд дараах байдлаар иргэдийн байр суурийг тандсан юм. Шүүхийн одоогийн дагнасан тогтолцоо болон өмнөх тогтолцооны алийг нь илүүд үзэж буйг ажигласан бөгөөд тухайн тогтолцооны гол гол, онцлог шинжүүдийг судлаач танилцуулж ажилласан.



График 4: Шүүхийн тогтолцооны өмнөх болон одоогийн хэлбэрийн алийг нь илүүд үзэх вэ?

Судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 50% нь шүүхийн өмнөх тогтолцоог илүүд үзэж буй бол үлдсэн 50% нь шүүхийн одоогийн тогтолцоог илүүд үзэж байна. Иргэдийн хувьд шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтүүдийг мэдэхгүй, шүүхийн шинэчлэлийн талаар мэдээлэлгүй байсан нь ийм үр дүн гарахад нөлөөлсөн гэж үзэж байна. Энэ нь иргэдэд шүүхийн тогтолцооны өөрчлөлт, өөрчилсний ач холбогдол, үр өгөөжийн талаар мэдээллийг хүргэх хэрэгцээ шаардлагатайг харуулж байлаа.

Хүснэгт №1. Өмнөх тогтолцоо болон одоогийн тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан.

Өмнөх тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан	Одоогийн тогтолцоог илүүд үзэж буй шалтгаан
<ul style="list-style-type: none"> • Анхан болон давж заалдах шатны шүүх нь тухайн аймагтаа, Төв аймагтаа байвал дээр. • Удаашралтай боловч чанартай байсан. • Хуучнаараа байхыг хүсэж байна. Газар нь хол ч бусад бүх ажлаа амжуулдаг. Багийн ахлагч нар бөөгнүүлээд аваад явдаг, холбож өгдөг. Гэрчийг байнга дууддаггүй, хайрцагт нь хийж авчирдаг байсан. • Аймаг унаа элбэг, зардал бага. Таних хүн элбэг. Ажлаар явах унаа нь элбэг учир дайгддаг, зам нэг зардал бага, танил олонтой, шүүх илүү ойр байсан нутаг орондоо байсан, таньдаг айлтай, цаг бага шаардана. • Өмнөх тогтолцооны хүнд үйлчлэх хүрээ нь илүү. 	<ul style="list-style-type: none"> • Чиглэл нь өөр болохдоо иргэндээ ойр шүүх рүү явуулж байна. • Хурдан шуурхай байгаа учраас. • Үйлчилгээ, хүртээмж өмнөхөөсөө сайжирсан хүмүүсийн ам сайн байгаа. • Төрөлжсөн болохоор арай хурдан болсон. • Шүүгчийн орон тоог нэмсэн. • Уг нь их зүгээр, ядаж 4 жил үүнийг туршиж үзэх хэрэгтэй. Улам боловсруулах хэрэгтэй, нэлээн түүхий. • Шүүгч тухайн чиглэлээр мэргэших бололцоо олгосон. • Шүүх хаана байх нь хамаагүй. Тэгш үйлчилдэг байх хэрэгтэй. Тахар их далайлган сүрдүүлдэг.

Өмнөх шүүхийн тогтолцоог илүүд үзэж буй иргэд нутаг усандаа байвал таньдаг айл олонтой, төв рүү унаа элбэг байдаг учраас зардал, цаг хугацааг хэмнэнэ зэрэг шалтгаануудыг нэрлэж байлаа. Харин одоогийн шүүхийн тогтолцоог илүүд үзэж буй иргэд шүүхэд хандсан тухайн иргэнийг ойр шүүхэд нь харьяалуулсан, шүүх дагнасан нь шүүгчийг мэргэших бололцоо олгож, хурдан шуурхай болсон зэрэг асуудлыг голчлон хөндөж байлаа.



График 5: Одоогийн тогтолцоог өмнөх шүүхийн тогтолцоотой харьцуулан үнэлсэн байдал

Шүүхийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотойгоор үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийг тогтоохдоо үйлчилгээний тодорхой шалгуурын хүрээнд үнэлгээ авсан юм. Иргэдийн хувьд шүүх тогтолцоо өөрчлөгдсөнөөр дараах асуудлууд илүү сайн болсон гэж үзэн сэтгэл ханамж өндөртэй байлаа. Үүнд:

1. Шүүхийг дагнасан хэлбэрээр байгуулсан нь 72.7 хувь
2. Шүүгч нэг чиглэлээр мэргэших бололцоо хангагдсан байдал 65.2 хувь
3. Шүүгчийн мэргэшсэн байдал 48 хувь зэргээр одоо хэрэгжиж буй шүүх тогтолцооны гол гол онцлог давуу талуудыг нэрлэсэн байна.

Харин шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр иргэдийн хувьд дараах асуудлууд тулгарч эхэлсэн бөгөөд сэтгэл хангалуун бус байна. Үүнд:

1. Иргэнээс гарах цаг хугацааг хэмнэх байдал 19.2
2. Иргэнээс гарах зардлыг хэмнэх байдал 20 хувь
3. Шүүхийн үйлчилгээний хүндрэл, чирэгдэл багассан 23.1 хувь зэргээр иргэнд өөрт нь тулгарч буй цаг хугацаа, зардал мөнгөтэй хамааралтай асуудлуудад сэтгэл хангалуун бус гэжээ.

Шүүхийн шинэтгэлд иргэдийн сэтгэл хангалуун бус байгаагийн үндсэн шалтгаан болох санхүү буюу зардалтай холбоотой асуудлуудын талаар дараагийн бүлэгт нарийвчлан авч үзнэ.

2.3. Дэд хэсгийн дүгнэлт

Судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 32.4 хувь нь шүүхээр үйлчлүүлсэн ч шүүх тогтолцооны өөрчлөлтийн талаар огт мэдээгүй гэж хариулсан. Энэ нь нэг талаас Төв аймгийн Зуунмод сумын СДШ-ээр үйлчлүүлсэн иргэдийн хариулт юм. Учир нь тэдгээр иргэдийн хувьд шүүхийн харьяалалд нь өөрчлөлт ороогүй сумдын иргэд учир шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнийг мэдээгүй байж болох юм. Харин Төв аймгийн Дэлгэрхаан, Жаргалант сумдын шүүхээр үйлчлүүлсэн иргэд шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнийг мэдэж байгаа нь шүүхийн харьяалалд нь өөрчлөлт орсон сумдын иргэдийн хувьд энэ зайлшгүй мэдэх хэрэгтэй, эсвэл нэг нь нөгөөдөө ам дамжин мэдээлэл дамжуулж байгаатай холбоотой. Нөгөө талаас шүүх байгууллагын талаарх мэдээллийг шүүхээр үйлчлүүлсэн иргэд хүртэл хангалттай

хэмжээнд авч чадахгүй байгаа явдал нь шүүх байгууллагын зүгээс иргэд олон нийтийг мэдээллээр хангах шаардлагатай гэж үзэхэд хүргэсэн. Шүүхийн тухай багц хууль хэрэгжиж, шүүх байгууллагын түүхэн дэх томоохон шинэчлэлийн ажил явагдаад 2 жилийг ардаа орхисон атал иргэд, олон нийт энэ талаар дуулж мэдээгүй байгаа нь аливаа шинэчлэлийн ажлыг зайлшгүй дагаж явах гол ажиллагаа буюу таниулах, мэдээлэх ажил зарим талаар орхигдсон болох нь харагдсан. Энэ нь иргэдийн дунд шүүхийн шинэтгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зөвхөн хот суурин газар явагдаж, хөдөө орон нутгийн иргэд энэ төрлийн мэдээллээс илт хоцрогдож буйг илэрхийлж байсан. Шүүх байгууллагын талаарх мэдээллийг шүүхээр үйлчлүүлсэн иргэд хүртэл хангалттай хэмжээнд авч чадахгүй байгаа явдал нь иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил дутмаг байгаагаас гадна иргэдийн зүгээс “олж мэдэх” хүсэл эрмэлзэл бага байгаа, шүүх, цагдаагийн зүгээс “иргэн өөрөө хуулиа олж мэдэх үүрэгтэй” гэх хандлага гаргадгаас их хамаарч байна. Мөн сүүлийн үед техник, технологийн хөгжлөө даган төрийн байгууллагууд цахим хэлбэрээр мэдээлэл, сурталчилгаагаа явуулах болсон. Харин ийнхүү “цахимаар мэдээллээ тараах” явдал нь нээлттэй, ил тод байдлын шалгуур үзүүлэлт болж чадах эсэх нь эргэлзээтэй асуудал юм. Ялангуяа манай улсын хувьд хүн амын талаас илүү хувь нь төвөөс алслагдмал оршин суудаг, интернетээс мэдээлэл авах нь бүү хэл телевизээс мэдээлэл авах боломж бүрэн бүрэлдээгүй өрхүүд байдаг бөгөөд эдгээр нийгмийн бүлэгт багтаж буй иргэдэд эрх зүйн болон эрх зүйн шинэтгэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл ямар түвшинд, хэрхэн авч байгаагаас гадна мэдээллийн агуулга буюу үнэн зөв мэдээлэл хүрч чадаж байгаа эсэх нь бас л эргэлзээтэй юм.

Шүүхийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотойгоор үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин, хандлагыг аваад үзвэл 50, 50 хувьтай байна. Иргэдэд одоогийн тогтолцооны давуу талуудыг танилцуулж, мэдээлэл хүргэхэд иргэдийн хандлага илүү эерэг болох боломжтой байна. Учир нь судалгаанд оролцогчид шүүхийг дагнасан хэлбэрээр байгуулж, шүүгч мэргэших бололцоо хангагдсан байдал зэрэг одоогийн тогтолцооны гол шинжүүдэд сэтгэл хангалуун байлаа. Мөн үүний нөгөө талд иргэдийн сэтгэл хангалуун бус байгаа асуудал нь иргэнээс гарах зардал болоод цаг хугацааг хэмнэх байдал хангагдаж чадаагүй, харин ч улам их болсноос үүдэлтэй байна. Энэ нь шүүхийг тойргийн журмаар байгуулахдаа тооцоо судалгааг сайтар хийгээгүйгээс гарч буй бэрхшээл юм.

БҮЛЭГ 3. Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр гарч буй үр дагавар, тулгарч буй хүндрэл бэрхшээл

3.1 Зардал, цаг хугацааны хувьд үр ашигтай байдал

Энэхүү хэсэгт шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр буюу Төв аймгийн Зуунмод сум явж шүүх байгууллагаар үйлчлүүлж байсан иргэн өөр аймгийн шүүхээр үйлчлүүлэх болсноор тухайн иргэнд учирч буй зардал болон цаг хугацааны ачааллыг үндсэн тооцоо болгон авч үзэх юм. Тус тооцоонд үндэслэн цаашлаад энэхүү хуулийн өөрчлөлтийн хүрээнд Төв аймгийн иргэд, олон нийтэд учрах зардлын ачааллыг таамаглах боломжтой. Иргэнд учрах зардал нэмэгдсэн буюу хуулийн өөрчлөлтийн хүрээнд хийсвэр зардал бий болсон тохиолдолд нийт эдийн засагт учрах нэмэлт зардлыг ч таамаглах шаардлага үүснэ⁴³.

Орон зайн хувьд авч үзвэл Зуунмод сум дахь шүүхээр үйлчлүүлж байсан нийт 10 сумыг Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Налайх дүүрэг, Багануур дүүргийн шүүхэд тус тус шилжүүлсэн нь Зуунмод сумын шүүхээр үйлчлүүлэхээс илүү ойр болсон.

⁴³ Гэвч бидний хувьд “цонх хагалсан хүүхэд эдийн засагт баялаг бүтээж буй эсэх” гэх зэрэгтэй дүйцэхүйц онолын болон эдийн засгийн нарийвчилсан судалгаа шаардагдах асуудлыг авч үзэх нь судалгааны зорилго биш тул зөвхөн хуулийн өөрчлөлтийн хүрээнд нэг иргэнд учирч буй зардлын өөрчлөлтийг боломжит хэмжээнд нарийвчлан, тухайн аймгийн иргэд, олон нийтэд учирч буй зардал, нийт бий болсон зардал зэргийг таамаглан ерөнхий төсөөлөл бий болгохыг зорив.

Хүснэгт №2. Орон зайн хувьд өөрчлөгдсөн байдал

Сумын нэр	Шилжүүлсэн шүүх, түүний байрлал, хүртэлх зай ⁴⁴	км — Зуунмод хүртэл ⁴⁵	
Эрдэнэсант	Сум дундын 18 дугаар шүүх, /Өвөрхангай аймаг, Хархорин сум/	143 км	248 км
Батсүмбэр	Сум дундын 21 дүгээр шүүх, /Сэлэнгэ аймаг, Мандал сум/		108 км
Борнуур		60 км	129 км
Жаргалант		95 км	180 км
Сүмбэр		54 км	178 км
Баяндэлгэр	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 3 дугаар шүүх,	32 км	109 км
Мөнгөнморьт	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүх, Багануур дүүрэг	73 км	211 км
Баян	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх,	78 км	84 км
Баянжаргалан	Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүх, Налайх дүүрэг	114 км	158 км
Эрдэнэ		39 км	82 км

Ийнхүү орон зайн хувьд ойр болсон боловч зардал, цаг хугацааны хувьд илүү хүндрэлтэй байна гэж судалгаанд хамрагдсан иргэд, өмгөөлөгчид үзэж байсан⁴⁶ нь дэд бүтцийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсээс шалтгаалж байна.

Судалгааны баг шүүгч, өмгөөлөгч, иргэдтэй хийсэн ярилцлага, иргэдээс авсан анкетын судалгааны үр дүнд тулгуурлан үндсэн зардал буюу замын зардлын өөрчлөлт болон нэмэлт зардлыг Төв аймгийн хувьд тодорхойллоо. Үүний зэрэгцээ цаг хугацааны хувьд үр ашигтай байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Төв аймгийн дээр дурдсан 10 сумын хувьд өмнөх тогтолцооны үед Улаанбаатар хот руу тухайн сумдаас тогтмол явдаг суудлын тэрэг, автобусаар зорчиж, улмаар Улаанбаатар - Зуунмод чиглэлийн автобусаар үйлчлүүлэх боломжтой байсан. Харин одоогийн үйлчлүүлж буй шүүхүүдийн байрлалыг авч үзэхэд зарим сумын иргэд дэд бүтцийн хөгжил сул, байнгын унаа явдаггүй зэрэг хүндрэлтэй асуудалтай тулгарч байна.

Тухайлбал, Налайх дүүргийн шүүхээр үйлчлүүлж буй Төв аймгийн Баянжаргалан, Эрдэнэ сумд орон зайн хувьд ойрхон болсон, дэд

⁴⁴ Google map ашиглан тооцов.

⁴⁵ Google map ашиглан тооцов.

⁴⁶ Ярилцлага 8. Шүүхийн тогтолцоо өөрчилсөн энэ шийдвэрийг бол иргэдэд маш их ачаалал нэмсэн шийдвэр гэж хэлж болно. Зардлын хувьд иргэдэд их ачаалал нэмсэн.

Ярилцлага 14. Амьдралын боломж хэцүү иргэдийн хувьд бол ялангуяа эхний үед маш хүндээр туссан.

бүтцийн хувьд засмал замаар явж хүрдэг, мөн эдгээр дүүргүүд Улаанбаатар хот орох зам дагуу байрлаж байгаа зэрэг давуу талууд үүссэн. Харин Өвөрхангай аймгийн Хархорин сумын шүүхээр үйлчлүүлж буй Эрдэнэсант сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын шүүхээр үйлчлүүлж буй Борнуур, Жаргалант сумд орон зайн хувьд илүү ойр болсон боловч шороон замаар явдаг, мөн суудлын тэрэг олж, хөлслөх шаардлагатай болсон байна.

Ярилцлага 21.

Давуу тал нь км-ийн хувьд бага болсон боловч санхүү, эдийн засгийн хувьд хүндрэлтэй. Зүүнхараа руу зорьсон машинаар, бензин хийж явах шаардлагатай болдог. Шороон замаар явдаг учраас явах хугацаа нь яг ижилхэн 2 цаг болчихдог.

Жаргалант сумын иргэн

Талбарын судалгаа хийгдсэн сумдын дэд бүтцийн нөхцөл байдлыг авч үзвэл зарим сумдын хувьд хүндрэлтэй болох нь харагдаж байна.

Хүснэгт №3. Дэд бүтцийн нөхцөл байдал /Төв аймгийн зарим сумын хувьд/

Очих чиглэл	Сумын нэр	Замын нөхцөл/ Ямар төрлийн унаагаар зорчих	Хүндрэлтэй эсэх/Тэмдэглэл
Өвөрхангай аймаг, Хархорин сум	Эрдэнэсант	Шороон зам / Тогтмол унаа байхгүй	Тогтмол унаа явдаггүй тул хүндрэлтэй байдаг.
Сэлэнгэ аймаг, Мандал сум	Жаргалант Борнуур	Шороон зам / Тогтмол унаа байхгүй	Тогтмол унаа явдаггүй тул хүндрэлтэй байдаг.
	Батсүмбэр	Төмөр зам / Тогтмол	Хүндрэлгүй / Төмөр замаар үйлчлүүлэх боломжтой тул өглөө ирээд тухайн өдөртөө багтаж вагоноор буцах боломжтой байдаг байна. ⁴⁷
Налайх дүүрэг	Баян	Засмал зам / Тогтмол	Хүндрэл бага / Улаанбаатар явах чиглэлийн унаанаас дамжих боломжтой
	Баянжаргалан Эрдэнэ	Засмал зам / Тогтмол	Хүндрэлгүй / Улаанбаатар явах зам дагуу байрлах тул тогтмол унаа явах боломжтой

⁴⁷ Мандал сумын шүүх Төв аймгийн сумдын нөхцөл байдлыг харгалзан үзэх тухайд анхаарал хандуулан ажиллаж байгаа талаар дурдсан:

Ярилцлага. Төв аймгаас манай шүүхэд харьяалуулсан сумдын иргэдийн хувьд бол бид нар аль болох чирэгдэл учруулахгүй, онцлогийг нь анхаарч ажиллахыг боддог. Жишээ нь, Батсүмбэрийн иргэд бол өглөөний вагоноор ирээд шууд шүүх хуралд ороод орой буцах боломжтой байдаг болохоор шүүгчийн туслуууд утасдаад өдөр тогтоод, шүүх хурлыг нь хамгийн эхэнд тавих байдлаар зохицуулаад явдаг.

Ярилцлага. Төв аймгийн иргэдэд хүндрэл учруулахгүй байх талаар анхаарч ажилладаг. Өглөө эрт хуралдаа ороод өдөр буцах боломжтой байдлаар шүүх хурлыг товлодог байгаа. Одоо бол ийм байдлаар жигдрээд, иргэдтэйгээ харилцан тохироод ажиллаж байна.

Харьяалах шүүхийн байрлал өөрчлөгдсөнөөр өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхээр үйлчлүүлэх шаардлагатай болсон Эрдэнэсант, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр гэсэн 5 сум орон зайн хувьд ойролцоогоор бүгд нэг дахин ойрхон болсон тул өмнөх ба шинэ тогтолцооны хувьд гарч буй зардлын үр нөлөөг тооцоход аль нэг сумыг жишээ болгон адилтгаж үзэх боломжтой юм. Иймд Жаргалант сумыг жишээ болгон үндсэн тооцооллыг гаргав⁴⁸.

Нэг иргэнд учрах зардлын өөрчлөлт: Жаргалант сумын жишээн дээр

Жаргалант сумын тухайд судалгааны баг талбарт нь очиж ажилласан бөгөөд цагдаа, сумын захиргааны зарим албан хаагчид, иргэдээс ярилцлага авч шүүхийн шинэчлэлийн хүрээнд шүүхийг тойргийн журмаар байгуулснаар тус сумын иргэд Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын 21-р шүүхээр үйлчлүүлэх болсонтой холбоотой ямар хүндрэл бэрхшээл, зардал гарч байгаа талаар тодруулсан юм.

Жаргалант сумаас 1. Төв аймгийн Зуунмод сум, 2. Сэлэнгэ аймгийн Мандал сум гэсэн хоёр чиглэлд зорчих үндсэн зардал буюу замын зардлыг дараах байдлаар тооцов. Үндсэн зардалд:

- Хоёр талд зорчих унааны зардал⁴⁹
- Хоолны зардлыг⁵⁰ авч үзсэн болно.

Ийнхүү Жаргалант сумаас Төв аймгийн Зуунмод сум болон Сэлэнгэ аймгийн Мандал суманд ирж үйлчлүүлэх зардлыг харьцуулан авч үзвэл:

Зураглал №1. Зардлын тооцоо: Иргэнд учрах үндсэн зардал буюу замын зардлын өөрчлөлт

Жишээ 1. Жаргалант сум

Жаргалант сумын иргэд Улаанбаатар хот руу зорчиход засмал замаар 180 км явдаг бол Сэлэнгэ аймгийн Мандал сум ороход 95 км шороон замаар явж хүрнэ. Мандал сум руу тухайлан хөлсөлсөн машинаар, шатахуун хийж явах шаардлага үүсдэг.

⁴⁸ Судалгааны баг Жаргалант суманд талбарын судалгаа хийсэн, Сум дундын 21-р шүүх байрлах Сэлэнгэ аймгийн Мандал суманд мөн ажилласан гэсэн хүчин зүйлийг харгалзан тус сумыг сонгов.

⁴⁹ Зардлыг тооцохдоо суудлын тэрэг 100 км-т 11 л дизель түлш зарцуулна гэсэн тооцооллыг ашиглав. /Ланд 80 загварын машин болон олон хүний багтаамжтай суудлын тэргүүдийн дунджаар/ Шатахууны үнийг 2015 оны эхний хагас жилийн үнээр тооцов.

⁵⁰ Зардал гэсэн анкетын асуултанд иргэд хоолны зардал 4 000 – 10 000 хооронд гэж хариулсан бөгөөд дунджаар 4 000 – 10 000 төгрөгийн хооронд багтааж нэг удаа хооллох боломжтой гэж үзээд хоолны зардлыг хоёр удаа хоолонд орно гэж тооцон дундаж байдлаар 10 000 төгрөг гэж тооцов.

Шүүхийн тогтолцоо
өөрчлөгдсөнөөр гарч
буй үр дагавар, тулгарч
буй хүндрэл бэрхшээл

Жаргалант

Зуунмод

УБ хот орох унааны зардал + УБ, Зуунмод чиглэлийн автобусны зардал + Хоолны зардал + Зуунмод, УБ чиглэлийн автобусны зардал + УБ хотоос буцах унааны зардал = Нийт /Жаргалант-УБ таксины үнээр тооцов./

10 000 төг + 2 000 төг + 10 000 төг + 2 000 төг + 10 000 төг = 34 000 төг

Жаргалант

Мандал

Хувилбар 1. Мандал хүрэх зардал /Суудлын жижиг тэрэг хөлслөх/ + Хоолны зардал = Нийт

80 000 төг + 10 000 төг = 90 000 төг

Хувилбар 2. Мандал хүрэх зардал /Хувийн унаатай иргэнээс гарах шатахууны зардал/ + Хоолны зардал = Нийт

/Шатахууны зардал = $11 \times 2 \times 1790$ буюу 39380 төг/

40 000 төг + 10 000 төг = 50 000 төг

Жаргалант сумын хувьд Төв аймгийн Зуунмод сум бус Сэлэнгэ аймгийн Мандал суманд очиж шүүхээр үйлчлүүлэх болсноор орон зайн хувьд ойртсон боловч дэд бүтцийн байдал хангалтгүй буюу тогтмол тээврийн хэрэгсэл явдаггүй, тухайлан тээврийн хэрэгсэл хөлслөх шаардлагатай болдгоос шалтгаалан зардал нэмэгдсэн нь харагдаж байна. Ийнхүү нэг иргэнээс гаргах замын зардлыг дундаж байдлаар авч үзвэл ойролцоогоор /50 000 төг – 34 000 төг/ = 16 000 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Шигтгээ №13.

Гэвч зарим сумын иргэд, төрийн албан хаагчидтай уулзаж, ярилцахад иргэд 2 жилийн хугацаанд харьцангуй дасах хандлагатай болж байгаа, зохион байгуулалттайгаар хэд хэдэн хүмүүс нийлж суудлын тэрэг хөлслөх байдлаар зардал хэмнэж байгаа талаар дурдсан.

Өмгөөлөгч

Ярилцлага 25.

Зайны хувьд бол ойр болж байгаа юм. 60 гаруй км шүү дээ. Одоо бол нийлж байгаад машинаар явдаг болчихсон. Эхлээд иргэд бол их дургүй байсан. Явах унаа байхгүй, очоод хонох айл байхгүй гэдэг байсан. Одоо бол дасчихсан. Иргэд хэд хэдээрээ нийлээд явдаг болчихсон.

Борнуур сумын ЗДТГ-ын ажилтан

Дээр дурдсан Жаргалант сумтай ижил төстэй нөхцөл байдал үүсээд буй 5 сумын хувьд үйлчлүүлэх шүүхийн орон зайг ойртуулсан мэт боловч зардлын хувьд эсрэгээр нэмэгдсэн байгаа нь сөрөг үр дагавар үүсгэж, иргэдийн ачааллыг нэмж байна

Харин дөрвөн хүн хамтран суудлын тэрэг хөлслөхөөр тохиролцсон тохиолдолд нэг хүнээс гарах зардлыг тооцвол:

Унааны хөлс $80\,000/4=20\,000$ төг + Хоолны зардал $10\,000$ төг = $30\,000$ төг

Энэ тохиолдолд Зуунмод руу ирж, буцах зардал болох $34\,000$ төгрөгөөс бага буюу зардлын хувьд хэмнэлттэй байх боломжтой боловч дурын нэг иргэний хувьд авч үзвэл шүүхээр үйлчлүүлэх өөр бусад хүмүүсийг хүлээх, зохион байгуулах зэргээр цаг хугацаа алдах эрсдэлтэй юм.

Хүснэгт №4. Жаргалант сум, замын зардлын өөрчлөлт

Дээр дурдсан тооцооллыг хүснэгтэд нэгтгэн харуулав.			
Байрлал	Унааны зардал	Хоолны зардал	Нийт зардал
Зуунмод	24 000 төг	10 000 төг	34 000 төг
Мандал /Суудлын тэрэг хөлслөх тохиолдолд/	80 000 төг	10 000 төг	90 000 төг
Мандал /Хувийн унаагаар явах тохиолдолд/	40 000 төг	10 000 төг	50 000 төг
Мандал /4 хүн хамтран унаа хөлслөх тохиолдолд/	20 000 төг	10 000 төг	30 000 төг

Үүнээс гадна хэрэг маргаан шийдвэрлэх хугацаанаас шалтгаалан нэгдүгээрт, хонох шаардлагатай болох, хоёрдугаарт, шийдвэрлүүлж буй маргааны төрлөөс хамааран иргэн өөрөө нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай иргэний хэрэг, маргааны⁵¹ хувьд Зуунмод суманд очиж баримт бүрдүүлэх шаардлага тулгарч байгаа нь нэмэлт зардал учруулж байна.

Эхний тохиолдлыг авч үзвэл Төв аймгийн ихэнх иргэдийн хувьд Зуунмод суманд таньдаг айл, хамаатан садан байдаг бөгөөд эсвэл УБ-т байгаа айлд хонодог. Иймд хуучин тогтолцооны үед Улаанбаатарт танил айлд хононо гэж тооцвол, дахин УБ-Зуунмод чиглэлд хоёр талд зорчих унааны зардал 4000 төгрөг, хоолны зардал $10\,000$ төгрөгийг нэмэхэд Зуунмод сум явж үйлчлүүлэх иргэн $14\,000$ төгрөгийн нэмэлт зардал гаргана.

⁵¹ Тухайлбал, ажилласан жил тогтоох, хамтын амьдралыг тогтоох зэрэгт аймгийн төвөөс лавлагаа авах зайлшгүй шаардлагатай.

Харин Мандал суманд хонох шаардлагатай бол буудалд болон хоолонд 40 000 төгрөгийн нэмэлт зардал гаргах шаардлага үүсэж байна⁵².

Хоёр дахь тохиолдолд 1. Зуунмод, 2. Мандал гэсэн хоёр чиглэлд явах шаардлагатай болж байгаа нь засаг захиргааны харьяаллын хувьд өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхээр үйлчлүүлэх болсон сумдын хувьд бүгдэд нь хамаарах юм. Харин хүснэгт 3-т үзүүлсэнчлэн Улаанбаатар явах зам дагуу байрлах Налайх, Багануур дүүргийн шүүхээр үйлчлүүлж буй сумдын хувьд хамаарахгүй.

Зураглал №2. Зардлын тооцоо: Жаргалант, Эрдэнэ сумдын харьцуулалт

Жишээ 2. Эрдэнэ сум

Төв аймгийн Эрдэнэ сумын иргэн шүүхэд нотлох баримт гаргаж өгөх зорилгоор Төв аймгийн Зуунмод сум зайлшгүй орох шаардлагатай гэж үзвэл:



Эрдэнэ сумын хувьд Налайх дүүрэг Зуунмод хотоос буцах чиглэлийн дагуу байрлах тул нэг удаагийн зорчилтоор нэхэмжлэл гаргах боломжтой.

Жишээ 3. Жаргалант сум

Төв аймгийн Жаргалант сумын иргэн шүүхэд нотлох баримт гаргаж өгөх зорилгоор Төв аймгийн Зуунмод сумзайлшгүй орох шаардлагатай гэж үзвэл:



Жаргалант сумын хувьд Зуунмод хот руу ирж буцах, түүний дараа Сэлэнгэ аймгийн Мандал сум руу ирж буцах хэрэгтэй буюу 2 удаа зорчих шаардлагатай болж байгаа юм.

Энд Улаанбаатараас Мандал руу шууд явах боломжтой боловч Зуунмод суманд ажлын нэг өдөрт л багтаж нотлох баримт бүрдүүлэх боломжтой тул Улаанбаатар хотод дахин нэг хонох шаардлагатай болно, мөн Мандалаас Жаргалант чиглэлийн унаа олоход хүндрэлтэй зэргийг харгалзан дээрх байдлаар зураглалаа.

⁵² Ярилцлага 8-ыг харна уу.

Дээрх жишээнд үзүүлснээр Улаанбаатар хот явах чиглэлийн дагуу байрладаг Налайх дүүргийн шүүхээр үйлчлүүлэх Баянжаргалан, Эрдэнэ сум, Багануур дүүргийн шүүхээр үйлчлүүлэх Мөнгөнморьт сумдаас бусад сумд буюу Эрдэнэсант, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баяндэлгэр гэсэн сумдын иргэд хоёр удаа, хоёр өөр чиглэлд явах шаардлагатай болж байгаа юм. Энэ нь зөвхөн зардал төдийгүй, цаг хугацааны хувьд ч үр ашиггүй байдлыг бий болгож байна. Шийдвэрлүүлж буй маргааны төрлөөс хамааран иргэн өөрөө нотлох баримт бүрдүүлэх шаардлага үүсдэг, Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны⁵³ хувьд Зуунмод сум явах шаардлага иргэнд тулгарч байгаа нь давхар зардал, цаг хугацааны хувьд ч үр ашиггүй байдлыг бий болгож байна. Үүнээс үзэхэд эдгээр сумдыг өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхийн харьяалалд шилжүүлэхдээ дагалдаж бий болох сөрөг үр дагаврыг, өөрийн нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхээр үйлчлүүлэх давуу талыг тус тус харгалзан үзээгүй гэж дүгнэж болохоор байна.

Энэ бүгдийг Жаргалант сумыг жишээ болгон тооцож үзвэл зардлын хувьд дараах нөхцөл байдал үүсэж байна.

Хүснэгт №5. Жаргалант сум, нийт зардлын өөрчлөлт

Зуунмод орох зардал	Мандал орох зардал	Нийт /хоёр чиглэлд/	Нэг өдөр хонох зардал	Нийт зардал
Суудлын тэрэг хөлслөх тохиолдолд				
34 000 төг	90 000 төг	124 000	40 000 төг	164 000 төг
Хувийн унаагаар явах тохиолдолд				
34 000 төг	50 000 төг	84 000 төг	40 000 төг	124 000 төг
Тогтолцоо өөрчлөгдсөнөөр бий болсон зардлын өөрчлөлтийг нэгтгэн харуулъя.				
Өмнөх тогтолцооны үед гарах зардал	Шинэ шүүхээр үйлчлүүлэхэд гарах зардал	Хоёр чиглэлд явах болсноор гарах нийт зардал	Нэмэгдэж болзошгүй зардал	Болзошгүй зардлыг тооцсон нийт зардал
Нэмэлт зардал = 16 000 төг		Нэмэлт зардал = 50 000 төг	Болзошгүй нэмэлт зардал=26 000 төг	Нийт нэмэлт зардал=92 000 төг

Ийнхүү нэг иргэнд учрах замын зардлын хэмжээ 16 000 төгрөгөөр, хоёр чиглэлд явах болсноор 50 000 төгрөгөөр, хонохоор бол нийтдээ 92 000 төгрөгөөр нэмэгдэж байгаа нь шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын

⁵³ Тухайлбал, ажилласан байдлыг тогтоох, хамтын амьдралыг тогтоох зэрэгт аймгийн төвөөс лавлагаа авах зайлшгүй шаардлагатай.

шийдвэр гаргахдаа иргэнд учрах зардлыг урьдчилан тооцоолсон эсэх, бусад нэмэлт зардлуудыг харгалзаж үзсэн эсэхэд эргэлзэхэд хүргэж байна. Түүнчлэн манай улсын дундаж орлоготой, цалинтай иргэний хувьд авч үзэхэд Зуунмод явах нэг өдрийн цалин 63 000 төгрөгийн⁵⁴ нэмэлт зардлыг тооцох хэрэгтэй болно.

Тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд хоёр удаа шүүх рүү явах шаардлагатай боллоо гэж үзэхэд нийт зардал $124\ 000 + 50\ 000$ /дахин нэг удаа Мандал орох унааны зардал/ = $174\ 000$ ⁵⁵ болж байгаа юм. Мөн иргэн шүүх байгууллагаар үйлчлүүлэх ажлын 2 өдөр, мөн Зуунмод орох 1 өдөр, нийт 3 өдрийн чөлөө авсан бол 3 өдрийн хөдөлмөрийн хөлс болох дунджаар $63000 \times 3 = 189\ 000$ төгрөг зарцуулсан гэвэл нэг иргэн шүүхэд хандаж иргэний хэрэг маргаан шийдвэрлүүлэх 97 хоногийн хугацаанд⁵⁶ $174\ 000 + 189\ 000 = 363\ 000$ төгрөгийн зардал гаргах болж байна.

Эрүүгийн хэрэгт холбогдон дуудагдаж байгаа иргэдийн хувьд дээрхтэй адил харьцангуй нарийвчилсан тооцоо гаргах боломж бага юм. Учир нь эрүүгийн хэргийн сэжигтэн, гэрч, холбогдогч нар шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд хэдэн ч удаа дуудагдах магадлалтай. Үүнээс үзвэл сэжигтэн, гэрч, хохирогч тус бүр дээр дурдсан замын зардлын алдагдал 16 000 төгрөгийг хэдэн ч удаа гаргах магадлалтай. Эрүүгийн нэг хэрэгт холбогдогч 10 хүнээс 5 удаа гэж тооцоход л $16\ 000 \times 5 \times 10 / 800\ 000$ төгрөгийн алдагдлыг бий болгож байна.

Шигтгээ №14.

Шүүх, цагдаа ядруу хүнд дээрэнгүй ханддаг. Би шүүхэд дуудагдаад хэлсэн өдөр нь унааны мөнгө олдоогүй болоод очиж чадаагүй. Хэд хоногийн дараа дахиж дуудагдаад очсон чинь “чи ер нь оргон зайлж магадгүй нөхөр байна” гээд хорьчихсон. Би угаасаа уушиг муутай хүн, хоригдож байх хугацаандаа чийгтэй, сэрүүн газар байж байгаад бүр хүнд болсон. Одоо бол эм, тарианд мөнгөө зарцуулаад сууж байна. Эрүүл мэндээрээ хохирсондоо гомдолтой явдаг.

Эрдэнэсант сумын иргэн

⁵⁴ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2014 оны 1 дүгээр улиралд нийт 33.4 мянган аж ахуйн нэгж, байгууллага хамрагджээ. Эдгээр байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 762.9 мян. төг, үүнээс эмэгтэйчүүдийнх 696.3 мян.төг, эрэгтэйчүүдийнх 829.9 мян. төг байсан бөгөөд үүнээс Төвийн бүсийн дундаж цалин 664 мян. төг байна. Сарын дундаж ажлын өдөр 21 хоногоор тооцвол өдрийн дундаж цалин 63 мян. төг болж байна.

⁵⁵ 98 000 төгрөг нь тухайн иргэн Зуунмод орж нотлох баримт бүрдүүлэх, Мандал орох зардлыг багтаасан тул хоёр дах удаад зөвхөн Мандал орох зардлыг авч үзэх хэрэгтэй.

⁵⁶ ИХШХШ тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д 60 хоногийн хугацаанд шийдвэрлэхээр заасан. ИХШХШ тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-г дээрх хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгах боломжтой бөгөөд иргэний хэргийг үүсгэх 7 хоногийн хугацааг оруулан тооцоход нийт 97 хоногт иргэний хэргийг шийдвэрлэхээр байна.

Төв аймагт явж байгаад зам, тээврийн осолд ороод энэ шүүхэд хэрэг нь шилжсэн. 7 хоногтоо байг 1 удаа Зуунмод ордог болсноос хойш удаж байна. Эхлээд ажлаасаа чөлөө гуйгаад, аргаа барахаараа акт аваад аргалдаг байсан, сүүлдээ дарга уурлаад ажлаасаа гарсан. Ажилгүй, орлогогүй болчихоор гэр бүл, хүүхдээ тэжээхэд хүнд байна. Энэ хэргийг нэг тийш нь болгож байж ажил хайна. Гэхдээ ажил олдоно гэдэгт нэг их итгэхгүй байна.

Сонгинохайрхан дүүргийн иргэн

Ийнхүү Төв аймгийн Жаргалант сумын иргэд өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхийн байгууллагаар үйлчлүүлэх болсон нь зардлын хувьд иргэдэд ачаалал нэмсэн, үр ашиггүй шийдвэр болжээ гэж дүгнэхэд хүргэж байна. Мөн нийтлэг биш хэдий ч зарим тохиолдолд иргэн зөвхөн замын зардал, хоолны мөнгө, хөдөлмөрийн хөлс гэх зардлаас гадна эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол амсах нь цөөнгүй байна.

Дээрх жишээнээс харахад иргэдэд учрах зардлын хэмжээг тогтоохдоо зөвхөн ил мэдэгдэж буй зардлыг бус эдийн засгийн хувьд далд гарч буй зардал үр нөлөөг тооцох нь бас чухал байна.

Шүүх байгуулах тухай хуулийн 2.1 болон 2.4 дэх заалтын хүрээнд бий болсон ачаалал: Төв аймаг

Хүснэгт №6. Хуулийн өөрчлөлтийн хүрээнд Төв аймгийн иргэдэд учирч буй зардлын ачаалал, Иргэний хэрэг маргаан⁵⁷

Зардал нэмэгдсэн утга	Нэг иргэний	Жаргалант сумын хүрээнд ⁵⁷	Төв аймгийн хүрээнд ⁵⁸	Тайлбар
		Хоёр жилийн хугацаанд		
Замын зардлын өөрчлөлт	16 000 төг	73x2x16 000 2 336 000 төг	365x2x16 000 11 680 000 төг	Тогтолцоо өөрчлөгдсөнөөр бий зардлын ачаалал хамгийн багаар ⁶⁰

⁵⁷ Нэг хүн нэг л удаа шүүхийн байгууллагад очих шаардлагатай болсон гэсэн хамгийн доод хэмжээгээр тооцоолсон болно.

⁵⁸ Шүүхийн байгууллага үйлчлүүлсэн иргэдийн тоог 2012 оноос хойш сум тус бүрээр мэдээлэхгүй байгаа тул сумаар нарийвчлан гаргах боломжгүй байна. Иймд дараах байдлаар төсөөлөн авч үзлээ. Мандал сумын Сум дундын 21 дүгээр шүүхийн 2014 оны 4 дүгээр улирлын тайлангаас үзэхэд тус шүүхээр нэг улиралд нийт 364 иргэний хэрэг шийдвэрлэсэн байна. Иймд Төв аймгаас үйлчлүүлж буй 4 сум, Мандал сум нийт 5 сумын хэмжээнд дундачлан авч үзвэл 73 хэрэг болж байна. Ингээд Жаргалант сумаас нэг жилд нийт 73 иргэний хэрэг шийдвэрлүүлсэн гэж үзье.

⁵⁹ Жаргалант сумаас нэг жилд нийт 73 иргэний хэрэг шийдвэрлүүлсэн гээд Төв аймгийн өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхээр үйлчлүүлж буй 5 сум нийт 365 иргэний хэрэг шийдвэрлүүлсэн гэж үзье.

⁶⁰ Нэг ч иргэн хэрэг шийдвэрлүүлэхдээ Зуунмод орох шаардлагагүй байсан гэж үзэх тохиолдлоор авч үзвэл гэсэн утга бүхий юм.

Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр гарч буй үр дагавар, тулгарч буй хүндрэл бэрхшээл

Хоёр чиглэлд явах болсноор бий болсон нэмэлт зардал	50 000 төг	73x2x50 000 7 300 000 төг	365x2x50 000 36 500 000 төг	Тогтолцоо өөрчлөгдсөнөөр бий болсон зардлын ачааллыг ойролцоогоор авч үзвэл ⁶¹
Хонох тохиолдолд гарах зардлын өөрчлөлт	26 000 төг	73x2x26 000 3 796 000 төг	365x2x26 000 18 980 000 төг	-
Нийт зардлын өөрчлөлт	92 000 төг	13 493 000 төг	67 160 000 төг	-

Өмнө дурдсанчлан хуулийн өөрчлөлтийн хүрээнд нэг иргэнд учрах зардал нэмэгдсэн буюу хийсвэр зардал бий болсон тохиолдолд нийт эдийн засагт учрах нэмэлт зардлыг ч таамаглах шаардлагатай юм. Иймд дээрх хүснэгтэд Төв аймгийн иргэд, олон нийтэд учирч буй нийт зардлыг таамаглан, ерөнхий төсөөлөл бий болгохыг зорив. Ингэхдээ өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхээр үйлчлүүлж буй Төв аймгийн 5 сумаас нэг жилд шийдвэрлүүлсэн нийт иргэний хэрэг маргааны тоог ойролцоогоор тооцоолж, хоёр жилийн хугацаанд шийдвэрлүүлсэн нийт хэргийн тоог зардлын өөрчлөлтөөр үржүүлэн нийт зардлын ачааллыг тооцоолов. Хамгийн багаар буюу нэг хүнээс гарах зардал 16 000 төгрөгөөр нэмэгдсэн гэж үзэхэд л хоёр жилийн хугацаанд нийт 12 орчим сая төгрөг, бусад болзошгүй нөхцөл байдлыг харгалзан тооцоход хоёр жилийн хугацаанд нийт 67 сая гаруй төгрөгийн нэмэлт зардал дээрх хуулийн заалтын хүрээнд бий болсон байна. Гэвч энэ нь тухайн иргэн шүүхэд нэг л удаа очих тохиолдлын тооцоо болохыг анхаарах нь зүйтэй буюу өөрөөр хэлбэл зардал хэд дахин илүү байх боломжтой.

Харин эрүүгийн хэрэгт холбогдсон иргэдийн хувьд дээрхтэй адил харьцангуй нарийвчилсан тооцоо гаргах боломж бага боловч доорх байдлаар ерөнхий төсөөлөл бий болгохыг зорилоо.

Шигтгээ №15.

Төв аймагт 2013 онд нийт 922, 2014 онд нийт 955 гэмт хэрэг гарсан байна. Нийт 27 сумын хэмжээнд авч үзвэл ойролцоогоор жилд нэг суманд 34 гэмт хэрэг гардаг гэж үзээд:

⁶¹ Бүх иргэн хэрэг шийдвэрлүүлэхдээ Зуунмод орох шаардлагатай болсон гэж үзсэн боловч хоёр дахин явах эсвэл хонох шаардлагатай болох тохиолдлыг оруулаагүй.

Хуулийн өөрчлөлтийн хүрээнд өөр аймгийн шүүхээр үйлчлүүлж буй 5 суманд гарах нийт гэмт хэргийн тоог 170-аар тооцож үзвэл

Гэрч, хохирогч, сэжигтний тоо ойролцоогоор нийт 680

Эдгээр иргэд шүүхээр үйлчлүүлсэн буюу нэг удаа ирж, очсон нийт 1360 тохиолдол гэж үзвэл нэмэгдсэн ачааллыг дараах байдлаар тооцож болно.

$1,360 \times 16,000 = 21,760,000$ төгрөгөөр иргэдээс гарах зардал нэмэгдсэн байна.

Хэдийгээр хуулийн өөрчлөлтийн хүрээнд бий болсон зардлын нэмэгдлийг нэг бүрчлэн гаргах боломжгүй боловч хамгийн бага хэмжээгээр бодоход 11 680 000 сая төгрөгийн зардал /Хүснэгт 6-г үзнэ үү./ шинээр бий болгосон байгаа нь зардлын хувьд иргэдэд ихээхэн хүндрэл учруулж буйг харуулж байна.

3.2. Дэд хэсгийн дүгнэлт

“Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ”-ний ажлын хүрээнд Жаргалант сумыг жишээ болгон иргэнд учрах эдийн засгийн үр нөлөөг авч үзэхэд ижил төстэй нөхцөл байдал үүсээд буй Төв аймгийн 5 сумын хувьд үйлчлүүлэх шүүхийн орон зайг ойртуулсан мэт боловч зардлын хувьд эсрэгээр нэмэгдсэн байгаа нь сөрөг үр дагавар үүсгэж, иргэдийн ачааллыг нэмж байна гэсэн дүгнэлтэд хүргэв. Эдгээр сумдыг өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхийн харьяалалд шилжүүлэхдээ үүнийг дагалдаж бий болох сөрөг үр дагаврыг, өөрийн нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхээр үйлчлүүлэх давуу талыг тус тус харгалзан үзсэн судалгаа, шинжилгээ шаардлагатай байсан гэж үзлээ.

Шийдвэрлүүлж буй маргааны төрлөөс хамааран иргэн өөрөө нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай иргэний хэрэг маргааны хувьд Зуунмод сум явах шаардлага тулгарч байгаа нь зөвхөн зардал төдийгүй, цаг хугацааны хувьд ч үр ашиггүй байдлыг бий болгож байна.

ДҮГНЭЛТ

“Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ”-ний ажлын хүрээнд шүүхийн бүтэц, тогтолцоог бүхэлд нь шинэчилж шүүхийг тойргийн журмаар байгуулсан нь шүүх байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ойртож, тэдний эрх ашигт нийцэж байгаа эсэхийг тодруулах, мөн шүүхүүдийн харилцан адилгүй ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүгч хэргийн төрлөөр дагнан мэргэших, шийдвэрийн чанарыг сайжруулах зорилгоор шүүхийг дагнан, бүсчлэн байгуулсан явдал нь зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоохыг зорилоо. Үүнээс гадна иргэдэд үүсэж буй эдийн засгийн буюу зардлын үр нөлөөг тооцох замаар өнгөрсөн 2 жилийн хугацаанд шүүхийн шинэчлэлийн хэрэгжилт ямар үр дүнд хүрсэн болох, шүүхийн шинэчлэлийн талаарх иргэдийн үзэл бодол, сэтгэл ханамжийг Төв аймгийн жишээн дээр судалсан.

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, түүнд шүүх эрх мэдлийг засаглалын бие даасан салаа болгон, аливаа нам, төрийн хараат байдлаас гаргах үзэл баримтлалыг оруулсан нь шүүхийн шинэтгэлийн эрх зүйн үндэс нь болсон юм. Шинэ ҮХ батлагдсан нь 70 гаруй жилийн турш нэгдмэл “босоо” тогтолцоотой байж, бүхэлдээ нам, төр засгийн нөлөөнд ажиллаж байсан шүүхийн тогтолцоог халж, ардчилсан засаглалын гурван тулгуур баганын нэг болох шүүх эрх мэдлийг хангах, шүүх байгууллага бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан шүүхийн салбарын шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох хууль тогтоомжийг боловсруулах, батлах ажил 10 гаруй жил идэвхгүй үргэлжилсэн. 2012 онд УИХ-аас Шүүхийн тухай багц хуулийг баталж, 2013 оноос эхлэн дагаж мөрдсөнөөр шүүхийн тогтолцоонд болон шүүгч хараат бус байх

эдийн засгийн баталгаа, эрх зүйн байдалд том эргэлт гарсан. 2013 оны Шүүхийн тухай хуульд шүүхийн бие даасан байдал, зохистой ачааллыг бий болгох, ил тод нээлттэй байх зарчмыг баталгаажуулах, шүүхийн дотоод хараат байдлыг бууруулах шинэчлэлийн зохицуулалтыг багтааснаас гадна шүүхийн бие даасан байдлыг баталгаажуулахын тулд эдийн засаг, улс төр, эрх зүй, аюулгүй байдал, зохион байгуулалтын чиглэлийн цогц баталгааг тусгаснаараа онцлог болсон. 2013 оноос эхлэн хэрэгжүүлснээс хойш багагүй шүүмжлэлд өртөж байгаа боловч хэрэгжүүлж буй ажлууд нь тодорхой үр дүнд хүрч, эерэг, сөрөг үр дагавар дагуулсаар байна. Шүүх байгууллага дагнасан, тойргийн шүүхийн тогтолцоонд шилжиж, бие даасан, төвлөрсөн төсөвтэй болж, түүнийгээ өөрөө захиран зарцуулах эрх эдэлдэг болсон, мөн шүүхийн дарга, шүүгч нарыг төрийн байгууллага, албан тушаалтан сонгон шалгаруулж, томилдог, ажлынх нь тайланг хүлээн авч түүнд үндэслэн дүгнэдэг байдлыг зогсоож мэдлэг, ур чадвараар бусдаа манлайлах хуульчийг сонгон шалгаруулж шүүгчээр томилдог болсон нь энэ шинэчлэлийн ажлын нэг үр дүн юм. Мөн шүүгчийн нийгмийн асуудлыг дээшлүүлэх, эдийн засгийн баталгаа болох цалингийн хэмжээг эрс нэмэгдүүлснээр шүүгчид тавигдах шаардлага, хариуцлагыг нэмэгдүүлэх боломж нээсэн зэрэг дорвитой ажлууд хийгдсэнийг энд давхар дурдаж болох юм.

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн ажлуудын дундаас шүүхийн тогтолцоотой холбоотой хийгдсэн өөрчлөлтүүдийн дүнд дараах нөхцөл байдал үүссэн байна. Үүнд:

Шүүгчийн мэргэших боломжийг хангах хүрээнд: Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орж, шүүгч хэрэг маргааныг дагнан шийдвэрлэх болсноор шүүгчийн ажлын ачаалал буурч⁶², тодорхой нэг чиглэлээр мэргэших, хэргийн материалтай бүрэн танилцаж, оновчтой шийдвэр гаргах нөхцөл бүрэлдэж байна гэж үзэж болох юм. Шүүх иргэний, эрүүгийн, захиргааны хэргээр дагнан үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь шүүгчийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэших боломж олгохын зэрэгцээ шүүгчийн ажлын ачаалал буурснаар шүүхийн үйлчилгээ хурдан, шуурхай болж, шүүгчийн гаргаж буй шийдвэрийн чанар сайжирч байгааг судалгаанд оролцсон шүүгч, өмгөөлөгч нараас авсан судалгаанаас харж болно.

Шүүхийн тогтолцооны өөрчлөлтөөс үүдэн холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаанд үүсэж буй үр дагавар: Шүүхийг тойргийн журмаар

⁶² “Шүүхийн байгууллагын менежментийн шинэчлэлийн үр дүн судалгаа” GIZ. 2013 он

байгуулж засаг захиргаа, түүнд нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулахдаа цагдаагийн болон прокурорын байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөөг тооцоогүйн улмаас ихээхэн хүндрэл, чирэгдэл үүсгэсэн тухай шүүмжлэл их байна. Шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөн нь цагдаа, прокурорын байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, багагүй чирэгдэл үүсгэж буй асуудлын нэг юм. Учир нь тухайн засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг дээрх байгууллагын алба хаагчид ажлын ачаалал нэмэгдсэн гэх шалтгаанаас илүүтэй бүтэц зохион байгуулалтын хувьд өөр нэгжтэй хамтарч ажиллахад одоо мөрдөгдөж буй дүрэм, журмын дагуу албан бичиг илгээж, хариуг нь авахаас эхлээд цаг хугацаа алдах зэрэг асуудалтай тулгарч байна. Эдгээр асуудлууд хууль сахиулах байгууллагад болон иргэдэд нэгэн адил бухимдал, чирэгдэл үүсгэж байна. Шүүх тойргийн журмаар ажиллаж байгаа ч цагдаа, прокурорын байгууллагын албан хаагчид засаг захиргааны нэгжийн хил хязгаарын дотор үйл ажиллагаа явуулж байгаа нь ажлын ачаалал, чанар, шуурхай байдал, харилцан уялдаа зэрэгт сөргөөр нөлөөлж байна. Шүүхийн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг бусад хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалал, хүний нөөц болон эдийн засгийн байдлыг судалж үзсэний үндсэн дээр харилцан уялдаатай зохион байгуулах шаардлагатай байсан гэж үзэв.

Иргэдэд мэдээлэл хүрэх байдал: Иргэдийн дунд “шүүх, цагдаатай нэр холбогдсоноо нуун дарагдуулах, энэ тухай хүнд ярихгүй байх нь зөв, болж бүтэхгүй хүн л шүүх, цагдаатай холбогддог” гэсэн ойлголт амь бөх оршсоор байгаа нь судалгааны явцад илэрч байсан юм. Энэ нь эрх зүйн шинэтгэл, шүүхийн шинэтгэлийн талаар мэдээлэл, сурталчилгаа, сургалт хангалтгүй явагдаж байгаагийн илрэл билээ. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх ардчилсан нийгэмд амьдарч буй иргэн хүн өнөөдөр шүүгч, цагдаагаас “төрийн төмөр нударга” хэмээн айж суугаа нь эмгэнэлтэй байна. Гэтэл шүүх, цагдаагийн байгууллага “хүчний байгууллага”-аас “үйлчилгээний байгууллага” болж өөрчлөгдөөд багагүй хугацаа өнгөрөөд буйг энд дурдахад илүүдэхгүй байх.

Эрх зүйн, түүн дотроо шүүхийн шинэчлэлийн талаар сонсоогүй, сонссон ч ойлгоогүй иргэн олон байна. Үүнээс харахад иргэдийн дунд шүүхийн шинэтгэлтэй холбоотой мэдээ мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил зөвхөн хот суурин газар явагдаж, хөдөө орон нутгийн иргэд энэ төрлийн мэдээллээс илт хоцрогддог байна. Судалгаанд хамрагдсан шүүх байгууллагаар үйлчлүүлсэн

иргэдийн 32.4% нь шүүхээр үйлчлүүлсэн иргэд байсан хэдий ч шүүх тогтолцооны өөрчлөлтийн талаар огт мэдээгүй гэж хариулсан. Шүүхийн тухай багц хууль хэрэгжиж, шүүх байгууллагын түүхэн дэх томоохон шинэчлэлийн ажил явагдаад 2 жилийг ардаа орхисон атал иргэд, олон нийт энэ талаар дуулж, мэдээгүй байгаа нь аливаа шинэчлэлийн ажлыг зайлшгүй дагаж явах гол ажиллагаа болох танилцуулах, мэдээлэх ажил зарим талаар орхигдсоныг харуулж байна. Шүүх байгууллагын талаарх мэдээллийг шүүхээр үйлчлүүлсэн иргэд хүртэл хангалттай хэмжээнд авч чадахгүй байгаа явдал нь иргэд олон нийтийг мэдээллээр хангах ажил дутмаг байгаагаас гадна иргэдийн зүгээс “олж мэдэх” хүсэл эрмэлзэл бага байгаа, шүүх, цагдаагийн зүгээс “иргэн өөрөө хуулиа олж мэдэх үүрэгтэй” гэх хандлага гаргагдсаар их хамаарч байна. Мөн сүүлийн үед техник, технологийн хөгжлөө даган төрийн байгууллагууд цахим хэлбэрээр мэдээлэл, сурталчилгаагаа явуулах болсон. Харин ийнхүү “цахимаар мэдээллээ тараах” явдал нь нээлттэй, ил тод байдлын шалгуур үзүүлэлт болж чадах эсэх нь эргэлзээтэй асуудал юм. Ялангуяа манай улсын хувьд хүн амын талаас илүү хувь нь төвөөс алслагдмал оршин суудаг, интернетээс мэдээлэл авах нь бүү хэл телевизээс мэдээлэл авах боломж бүрэн бүрэлдээгүй өрхүүд байдаг. Үнэндээ улсынхаа нийслэлтэй хамгийн ойр орших Төв аймгийн иргэдэд хүрч буй мэдээлэл ийм түвшинд байхад алслагдсан буюу улсын баруун, зүүн хязгаарт амьдарч буй иргэдэд хүрч буй мэдээллийн төрөл, хэмжээ, чанар ямар байгааг төсөөлөхөд ч бэрх санагдсаныг нуух юун.

Иргэдийн сэтгэл ханамжийн тухайд: Шүүхийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотойгоор шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин, хандлагыг аваад үзвэл 50, 50%-тай байна. Иргэдэд одоогийн тогтолцооны давуу талуудыг танилцуулж, мэдээлэл хүргэхэд иргэдийн хандлага илүү эерэг болох боломжтой байна. Учир нь судалгаанд оролцогчид шүүхийг дагнасан хэлбэрээр байгуулж, шүүгч мэргэших бололцоо хангагдсан байдал зэрэг одоогийн тогтолцооны үндсэн шинжүүдэд сэтгэл хангалуун байлаа. Иргэд сэтгэл хангалуун бус байгаа нэг асуудал нь тэднээс гарах зардал болоод цаг хугацаа хэмнэх боломж хангагдаж чадаагүй, харин эсрэгээрээ улам нэмэгдэж, чирэгдэл, хүндрэл ихтэй болсон байдал юм. Энэ нь шүүхийг тойргийн тогтолцоонд шилжүүлэхдээ тооцоо судалгааг сайтар хийгээгүйгээс гарч буй бэрхшээл юм. Иргэдийн сэтгэл ханамжийн түвшинд сөргөөр нөлөөлж буй шалтгааныг авч үзвэл нэгдүгээрт, иргэд шүүхийн шинэтгэлийн талаар мэдээлэлгүй байсан, хоёрдугаарт, хэдийгээр орон зайн хувьд ойрхон тойргийн шүүхэд харьяалагдсан боловч нийтийн

тээвэр, замын нөхцөл муу, энэ төрлийн дэд бүтэц хөгжөөгүй байгаа, гуравдугаарт, орон нутгийн иргэдэд эдийн засгийн дарамт, ачаалал үүсгэж байгаатай шууд холбон ойлгож болох юм

Шүүхийн тогтолцооны шинэтгэлийн үр дүнд шүүх иргэдэд ойртсон эсэх: Шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орсноор иргэдэд үүсэх ачаалал буюу зардлын үр нөлөөг Төв аймгийн жишээн дээр тооцож үзэхэд хууль санаачлагчийн “шүүхийг иргэдэд ойр сум, дүүрэгт харьяалуулан, тойргийн журмаар байгуулах нь шүүхийн үйлчилгээг иргэдэд аль болох ойртуулах” гэсэн санаатай нийцүүлэн шүүхийн орон зайг ойртуулсан мэт боловч бодит байдал дээр зардлын хувьд эсрэгээрээ буюу улам нэмэгдсэн байгаа нь сөрөг үр дагавар үүсгэж, иргэдийн ачааллыг нэмж байна буюу улам холдуулсан гэсэн дүгнэлтэд хүрэв. Учир нь жишээ болгон авсан сумдыг өөр аймгийн нутаг дэвсгэрт байрлах шүүхийн харьяалалд шилжүүлэхдээ дагалдаж бий болох сөрөг үр дагаврыг, өөрийн нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхээр үйлчлүүлэх давуу талыг тус тус харгалзан үзсэн судалгаа, шинжилгээ хийж, бодит нөхцөл байдалд тулгуурласан шийдвэр гаргах шаардлагатай байсан гэж үзлээ.

Эцэст нь дүгнэхэд 2013 оноос эхлэн Шүүхийн тухай хууль, Шүүх байгуулах тухай хууль хэрэгжсэнээр МУ-ын шүүхүүд тойргийн журмаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь зарим тал дээр ололт, дэвшилттэй алхам арвинтай байсан хэдий ч хуулийн үндсэн зорилгыг зохицуулсан асуудлын хүрээнд зорилгодоо хүрээгүй байна гэж үзлээ. Дээрх хуулиуд хэрэгжиж эхэлснээр 1. шүүх, шүүгчийн хараат бус, бие даасан байдал, эрх зүй болон эдийн засгийн аюулгүй байдал сайжирсан, 2. шүүгч нэг төрлийн хэргээр дагнан мэргэшиж байгаа тул хэрэг маргаанаа хурдан шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд шийдвэрлүүлэх боломж бүрдэж байгаа зэрэг ололттой зүйл олон байна. Анхан болон давж заалдах шатны шүүхийн байршил өөрчлөгдсөнөөр түүнийг дагалдан гарч буй хүндрэл бэрхшээл, зардалтай холбоотой асуудлууд иргэдийг чирэгдүүлж, хохироож байгаагаас гадна шүүхтэй үйл ажиллагааны хувьд уялдаа холбоотой ажилладаг прокурор, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хүндрүүлж байгаа нь шүүхийн тогтолцоог өөрчилсөн тус бодлогын шийдвэр нь зарим талаар үндсэн зорилгодоо хүрч чадахгүй байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Эрх зүйт төрийн 3 дахь эрх мэдэл буюу шүүх эрх мэдлийн үндсэн нэгжийн нэг болох шүүхийн тогтолцооны МУ-дахь өнөөгийн нөхцөл байдлын талаар “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилтэд хийх шинжилгээ”-ний ажлаар Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2 жил гаруйн хугацаанд шүүхийн тогтолцооны энэхүү өөрчлөлт нь иргэдэд ямар үр дагавар үүсгэж байгаад өнгөц шинжилгээ хийлээ.

Тус судалгааны ажлаар шүүхийн тогтолцооны хөгжил ба шүүхийн шинэчлэлийн үр нөлөө, шүүхийн шинэчлэлийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшин болон тойргийн журмаар байгуулагдсан шүүхийн тогтолцоо буюу шүүхэд хандаж буй иргэнд учирч буй ачаалал буюу зардлын үр нөлөөг хөндсөн юм.

Судалгааны ажлын хүрээнд судалсан материал, судалгаанд оролцсон иргэдийн санал сэтгэгдэл, шүүмжид тулгуурлан дараах үндсэн 4 чиглэлээр судлаачийн санал зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Иргэд, олон нийтэд чиглэсэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах

Шүүхийн тогтолцооны шинэчлэл, өөрчлөлтийн талаар иргэдэд хүргэх мэдээ, мэдээллийн төрөл, хэлбэр, арга замыг сайжруулах нь нэн тулгамдсан асуудал байна. Өнөөдөр хүн ам олноороо суурьших хот суурин газар болон цахим хуудас, телевизээр дамжуулан мэдээлэл хүргэж байгаа нь хүн бүрт мэдээлэл түгээх, тэгш хүргэх шаардлагыг хангахгүй байна. Ялангуяа алслагдсан бүсийн⁶³ иргэд энэ тал дээр илт

⁶³ Судалгааны баг энэ удаад зөвхөн Төв аймгийг жишээ болгон сонгож, тус аймгийн төвийн болон захын сумдад талбарын судалгаа хийсэн. Захын сумдын иргэдийн мэдлэг, мэдээллийн түвшин төвийн сумдын иргэдийнхээс илт муу байсан юм. Гэтэл өнөөдөр МУ-ын төвийн бүсэд хамаарах Төв аймгийн

хоцрогдсон байна. Интернет сүлжээ бүх газруудад байдаггүй, өрхийн оршин суугаа газар, амьжиргааны түвшнээс хамааран компьютер, ухаалаг гар утас айл бүрт байхгүй учир иргэдийнхээ амьдралын хэв маяг, нөхцөл байдалд тохируулан мэдээлэл хүргэх арга замыг боловсруулах шаардлагатай байна.

2. Иргэдэд үүсэж буй ачааллыг бууруулах чиглэлээр

Шүүхийн байршил өөрчлөгдсөнөөр иргэдэд үүсэж буй зардал хэргийн онцлогоос хамааран зарим тохиолдолд даруй 2-4 дахин өссөн нь иргэн, айл өрхийн эдийн засагт хүндээр тусах нь гарцаагүй. Иймд шүүхийн харьяаллыг шинэчлэн тогтоосон энэхүү шийдвэрийг дахин авч үзэх, иргэдэд учирч буй хүндрэлийг харгалзан өмнөх харьяаллыг сэргээх, мөн цаашдаа аливаа бодлогын шийдвэр гаргахад зайлшгүй урьдчилсан тандалт судалгаа, нөхцөл байдлыг үнэлсэн судалгааг гүйцэтгэж хэвших, хийгдсэн судалгаа, шинжилгээний материалыг нээлттэй байлгах шаардлагатай байна.

Шүүхийн үйл ажиллагаанд чиглэсэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Шүүх, цагдаа, прокурорын байгууллагын үйл ажиллагааны харилцан уялдааг сайжруулах чиглэлээр

Судалгааны ажлын хүрээнд шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын зүгээс дэвшүүлсэн гол санал нь шүүхийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор цагдаагийн болон прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журамд зохих өөрчлөлт оруулах, үйл ажиллагааг уялдуулах хэрэгцээ, шаардлага үүссэн тухай байлаа. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авах шаардлага байна. Үүнд:

- Засаг захиргааны нэг нэгжийн хил хязгаар дотор үйл ажиллагаа явуулах эрх бүхий удирдлагын “босоо” тогтолцоотой дээрх байгууллагуудын албан хаагчид өөр аймагт байрлах шүүхэд шийдвэрлэгдэж буй хэрэгт холбогдох нотлох баримт бүрдүүлэх, мэдүүлэг авах асуудлаар харилцахад хүндрэлтэй байгаа тул одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журамд зохих өөрчлөлт оруулах,
- Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хүрээнд шүүхтэй зайлшгүй уялдаж ажилладаг цагдаа, прокурорын

захын сумын иргэн мэдээлэл авч чаддаггүй, авах боломжоор хангагдаагүй шахам байхад МУ-ын захын аймгуудын сумдад хүрч буй цаг үеийн асуудлаархи мэдээллийн хэмжээ, чанар, хугацааг тогтооход үнэхээр асуудалтай санагдаж байлаа.

бүтэц, зохион байгуулалтад зохих өөрчлөлт оруулаагүй. Энэ асуудлыг нарийвчлан судалсны үндсэн дээр тэдгээр байгууллагын хүний нөөцийн болон санхүүгийн байдалд хүндрэл учруулж буй нөхцөл байдлыг арилгах шаардлагатай байна гэж үзлээ. Тухайлбал цагдаагийн болон прокурорын байгууллагыг шүүхийн нэгэн адил тойргийн тогтолцоонд шилжүүлэх арга замыг эрэлхийлэх;

- Шүүх байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт, шинэчлэл хийх тохиолдолд түүнтэй харилцан уялдаа холбоотой ажилладаг байгууллагуудаас санал авах, санал бодлыг харгалзан үзэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, хамтарсан ажлын хэсэг байгуулах зэргээр арга хэмжээ авч хүрэх үр дүнг урьдчилан тодорхойлдог байх;

2. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудыг мэдээллээр хангах, тэдний санал бодлыг үйл ажиллагаандаа тусгах чиглэлээр

Шүүхийн байршлыг шинэчлэн тогтоохдоо нутаг дэвсгэрийн байршил, хүн амын нягтаршил, хэрэг, маргааны шийдвэрлэлтийн тоо, дэд бүтэц зэргийг хэрхэн тооцож үзсэн, энэхүү тооцоолол нь бодит байдалтай нийцсэн эсэх талаар хийсэн судалгааны материал олдоогүй тул ийм судалгаа хийгдээгүй байх магадлал өндөр байгаа хэдий ч магадгүй хэн нэгний ширээнд хадгалаатай байхыг үгүйсгэх аргагүй юм. Аливаа нэг шинэчлэл, шинэлэг үйл ажиллагаа явуулахдаа судалгаа шинжилгээ хийж хэвших, түүнийхээ үр дүнг олон нийтэд таниулах нь зүйтэй юм. Тухайлбал судалгааны хүрээнд шүүхийн байршлыг юунд, ямар судалгаанд үндэслэн, хэрхэн тогтоосон байж болох тухай асуухад иргэн, цагдаа, прокуророос гадна шүүхийн захиргааны ажилтан, шүүгчид хариулж мэдэхгүй, ямар ч ойлголтгүй байсан нь энэ талаар судалгаа хийгдсэн эсэхэд эргэлзээ төрүүлж байсан юм. Иймд:

- Шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, хийгдэж буй үйл ажиллагааны талаар шүүгч, шүүхийн захиргааны ажилтан болон тахарын албаны албан хаагчид мэдээлэл муутай байгааг өөрчилж тэднийг мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулах;
 - ✓ Дээрх чиглэлээр дотоод сургалт тогтмол хугацаанд явуулах;
 - ✓ Шүүхийн шинэчлэл, үйл ажиллагаанд шүүгч болон шүүхийн захиргааны ажилтнуудын саналыг харгалзан үзэх;

- Шүүхийн тогтолцоог шинэчлэхийн өмнө шинэчлэх хэрэгцээ шаардлагыг тогтоосон судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийт, тэр дундаа шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад ухуулж, тайлбарлаж, танилцуулах шаардлага одоог хүртэл байна.

3. Шүүхийн төсөвт холбогдох асуудлаар

- Төв аймгийн 10 сум өөр аймгийн шүүхэд харьяалагдах болсноор иргэдэд илүү хүртээмжтэй, хурдан шуурхай үйлчлэхэд шаардагддаг дараах төсөв 50 гаруй хувиар багассан талаар сум дундын 23 дугаар шүүхийн захиргааны ажилтнууд ярьсан. Тухайн шүүхийн 2012-2015 оны төсвийн мэдээллийг харахад бензин шатахууны зардал, томилолтын зардал хоёр багассан байна. Энэ нь шүүгч нүүдэллэн шүүх хуралдаан зохион байгуулах, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах /нээлттэй шүүх хуралдаан зохион байгуулах зэрэг/ асуудлыг бараг боломжгүй болгосон тухай шүүгч нар саналаа хэлсэн.

Мөн тэдний зүгээс хэргийг давж заалдах шатны шүүхэд хүргүүлэхэд шуудангийн зардал багассанаар тодорхой хугацаанд богц илгээдэг болсон нь хэрэг маргааныг хурдан шуурхай шийдвэрлэхэд саад болж байна гэж байв. Тухайлбал анхан шатны шүүхийн шийдвэрийн дараа эрүүгийн хэргийн холбогдогч иргэн давж заалдах шатны шүүх хурал хүртэл хоригдож буй ноцтой асуудлыг өмгөөлөгчид хөндсөн. Үүний шалтгааныг шүүгч нарын зүгээс шуудангийн төсвийг хассантай холбогдуулан тайлбарлаж байсан боловч Төв аймгийн шүүхийн захиргааны төсвөөс харахад шуудан, харилцаа холбоо, интернетийн зардал буураагүй өссөн дүнтэй байлаа. Иймд:

- ✓ Иргэний эрхийг зөрчиж буй дээрх асуудлын бодит учир шалтгааныг илрүүлж, зөрчлийг арилгах зэрэг зөвлөмжийг судалгааны багын зүгээс дэвшүүлж байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он
2. Шүүх байгуулах тухай хууль, 1993 он
3. Шүүх байгуулах тухай хууль, 2013 он
4. Шүүхийн тухай хууль 1993 он
5. Шүүхийн тухай хууль 2012 он
6. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төсөл болон түүнтэй холбогдох бусад хуулийн төслийн танилцуулга
7. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”, УИХ-ын 2000 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 39 дүгээр тогтоол
8. “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, УИХ-ын 1998 оны тогтоол
9. “МУ-ын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, УИХ-ын 1998 оны тогтоол
10. “Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, УИХ-ын 1998 оны тогтоол

Ном, бусад эх сурвалжууд

1. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
2. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо. С.Жанцан. 2005 он. УБ хот
3. Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо. ХЗҮХ, ШУА, МУИС-ийн Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүй судалгааны төв. 2005 он. УБ хот
4. Шүүхийн менежментийн үндсэн асуудлууд гарын авлага. ШЕЗ. 2008 он. УБ хот
5. Шүүх эрх мэдлийн шинэтгэл. МУИС-ийн Хууль зүйн сургууль, ХЗҮХ, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Увс аймгийн шүүх. 2012 он. УБ хот

6. “Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан”, ННФ. 2008 он. УБ хот
7. Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 2014. ЦЕГ
8. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл судалгааны тайлан”, ННФ. 2010 он. УБ хот
9. “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь бодлогын тойм судалгаа”, ННФ. 2010 он. УБ хот
10. “Шүүх эрх мэдлийн шинэтгэл сэдэвт онол, практикийн бага хурлын эмхэтгэл”. 2012 он. УБ хот
11. “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага” судалгааны тайлан. ХЗҮХ. 2012 он. УБ хот
12. “Судалгааны тайлангийн эмхэтгэл”, ШЕЗ, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. 2014 он. УБ хот
13. “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд сэдэвт олон улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл”. 2014 он. УБ хот
14. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2015 он, цуврал 51(1)
15. “Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай мэдээллийг Та авч чадаж байна уу?” мониторинг. ШЕЗ 2015 он
16. “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” судалгааны тайлан. ШЕЗ. 2015 он
17. Шүүхийн байгууллагын менежментийн шинэчлэлийн судалгаа” GIZ. 2013 он

Цахим хуудас

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <http://legalinfo.mn/>
2. Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан: <http://shuukh.mn/>
3. Шүүхийн ерөнхий зөвлөл: <http://www.judcouncil.mn/>
4. МУ-ын Ерөнхийлөгчийн цахим хуудас: <http://www.president.mn/>
5. Хууль зүйн яамны цахим хуудас: <http://www.moj.gov.mn/>
6. Сангийн яамны цахим хуудас: <https://www.mof.gov.mn/>
7. УИХ-ын цахим хуудас: <http://www.parliament.mn/>
8. Улсын дээд шүүхийн цахим хуудас: <http://www.supremecourt.mn/>
9. Үндсэн хуулийн цэцийн цахим хуудас: <http://conscourt.gov.mn/>
10. Нээлттэй Нийгэм Форумын цахим хуудас: <http://www.forum.mn/> болон бусад цахим эх сурвалж ашигласан болно.

ХАВСРАЛТ

Хавсралт № 1.

СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН (Иргэд олон нийт. $\Sigma=74$)

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ:

1. Та 2013 оноос өмнө шүүх байгууллагаар үйлчлүүлж байсан уу?

№		Тоо	Хувь
1	Шүүхэд хандаж байгаагүй	56	75,7
2	1 удаа үйлчлүүлж байсан	16	21,6
3	2 болон түүнээс дээш удаа үйлчлүүлж байсан	2	2,7

2. Та 2013 оноос хойш шүүх байгууллагаар үйлчлүүлж байсан уу?

№		Тоо	Хувь
1	Шүүхэд хандаж байгаагүй	32	43,2
2	1 удаа үйлчлүүлж байсан	26	35,1
3	2 болон түүнээс дээш удаа үйлчлүүлж байсан	12	16,2
4	Үйлчлүүлэх гэж байна.	4	5,4

3. Шүүх байгууллагын тогтолцоо өөрчлөгдсөнийг мэдсэн үү?

№		Тоо	Хувь
1	Сайн мэднэ	30	40,5
2	Зарим талаар мэднэ	20	27,0
3	Огт мэдээгүй	24	32,4

4. Та шүүх байгууллагаар үйлчлүүлснээс хойш хэр удаж байна вэ?

№		Тоо	Хувь
1	1-3 сар	22	44,0
2	2. 4-6 сар	8	16,0
3	3. 7-12 сар	8	16,0
4	4. 1 жилээс дээш	12	24,0

5. Шүүх байгууллагаар үйлчлүүлэхдээ ямар төрлийн хэрэг маргаан шийдвэрлүүлсэн бэ?

№		Тоо	Хувь
1	Иргэний	30	55,6
2	Эрүүгийн	20	37,0
3	Захиргааны	4	7,4

6. Та хэрэг маргаанаа аль /хот, дүүрэг, аймаг, сум/ шүүхээр шийдвэрлүүлсэн болохоо бичнэ үү?

№		Тоо	Хувь
1	Зуунмод	22	42,3
2	Налайх	10	19,2
3	Хархорин	4	7,7
4	Зүүнхараа	16	30,8

7. Таны хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүх байгууллага Танд

1.	орон зайны хувьд:	ойртсон	холдсон	хэвэндээ
		69,2	26,9	3,8
2.	цаг хугацааны хувьд:	хурдан	ялгаагүй	удаан болсон
		22,2	44,4	33,3
3.	замын зардлын хувьд:	өссөн	ялгаагүй	хэмнэлттэй
		56,0	36,0	8,0
4.	шүүгчийн орон тоо:	хэт олон	хэвийн	цөөн
		18,5	81,5	
5.	шүүх хуралдааны тов:	улам уддаг	ялгаагүй	хурдассан
		30,8	46,2	23,1

8. Та анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдсан уу?

Давж заалдсан эсэх	Давж заалдахад тулгарсан бэрхшээл болон давж заалдаагүй шалтгаан	Тоо	Хувь
1. Тийм	Давж заалдахад ямар нэгэн бэрхшээл тулгараагүй.	4	28,6
	Давж заалдах шатны шүүх иргэдээс холдсон.	2	14,3
	Давж заалдахад хугацаа их орсон.	4	28,6
	Давж заалдахад зардал мөнгө их орсон.	2	14,3
	Бүгд	2	14,3
2. Үгүй	Давж заалдах бүрэн боломж байсан, шүүхийн шийдвэртэй санал нийлсэн.	12	54,5
	Давж заалдах шатны шүүх хол болсон учраас	4	18,2
	Давж заалдах шатны шүүх хол учраас хугацаа их орно.		
	Давж заалдах шатны шүүхээр хол учраас зардал мөнгө их орно.	2	9,1
	Бүгд	4	18,2

9. Та өмнөх шүүхийн тогтолцооны талаар мэдэх үү?

№		Тоо	Хувь
1	Тийм	14	21,2
2	Зарим талаар мэднэ	26	39,4
3	Үгүй	26	39,4

10. Та одоогийн тогтолцоог өмнөх шүүхийн тогтолцоотой доорх өгөгдлүүдийн хүрээнд харьцуулан үнэлнэ үү?

№	Үнэлэх зүйл	Сайн	Дунд	Муу
1	Шүүгч нэг чиглэлээр мэргэших бололцоо хангагдсан байдал	65,2	30,4	4,3
2	Шүүгчийн орон тоо нэмэгдсэнээр хэрэг маргааныг хурдан шийдвэрлэх байдалд өөрчлөлт орсон эсэх	36,4	40,9	22,7
3	Шүүхүүдийг дагнасан хэлбэрээр байгуулах нь	72,7	18,2	9,1
4	Шүүхүүдийг бүсчилсэн хэлбэрээр байгуулах нь	45,5	22,7	31,8
5	Шүүхүүдийг тойргийн системд шилжүүлснээр иргэнд ойртсон, шүүхийн ачаалал багассан эсэх	29,2	41,7	29,2
6	Иргэнд тэгш үйлчлэх	36,0	40,0	24,0
7	Иргэнээс гарах зардлыг хэмнэх байдал	20,0	36,0	44,0
8	Иргэнээс гарах цаг хугацааг хэмнэх байдал	19,2	38,5	42,3
9	Шүүгчийн мэргэшсэн байдал	48,0	44,0	8,0
10	Шүүхийн үйлчилгээний хүндрэл, чирэгдэл багассан эсэх / нотлох баримт, гэрч дуудах гэх мэт??/	23,1	38,5	38,5

11. Дараах онцлог шинжээс үзвэл шүүхийн тогтолцооны өмнөх болон одоогийн хэлбэрийн алийг нь илүүд үзэх вэ?

№		Тоо	Хувь
1	Өмнөх тогтолцоо		50
2	Одоогийн тогтолцоо		50

СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

12. Таны нас

№		Тоо	Хувь
1	18-24 нас	4	5,4
2	25-30 нас	8	10,8
3	31-35 нас	12	16,2
4	36-40 нас	6	8,1
5	41-45 нас	14	18,9
6	46-50 нас	6	8,1
7	51-55	12	16,2
8	56-60	12	16,2
9	61 ба түүнээс дээш	2	2,7

13. Таны хүйс

№		Тоо	Хувь
1	Эрэгтэй	40	55,6
2	Эмэгтэй	32	44,4

14. Таны боловсролын түвшин

№		Тоо	Хувь
1	Боловсролгүй	2	2,8
2	Бага (3/4 анги)	2	2,8
3	Суурь (8/9 анги)	16	22,2
4	Бүрэн дунд (10/11/12 анги)	20	27,8
5	Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ)	10	13,9
6	Тусгай мэргэжлийн дунд(Коллеж)	8	11,1
7	Дээд	14	19,4

15. Таны хөдөлмөр эрхлэлт

№		Тоо	Хувь
1	Төрийн захиргааны байгууллагад	2	2,9
2	Төрийн үйлчилгээний байгууллагад	6	8,6
3	Хувийн компанид/хувийн томоохон компанид ажилладаг	6	8,6
4	Хувиараа бизнес эрхлэг/өөртөө ажил олгогч	12	17,1
5	Өндөр насны тэтгэвэрт	14	20,0
6	Оюутан	2	2,9
7	Малчин	12	17,1
8	Ажилгүй	12	17,1
9	Группт	4	5,7

16. Танай өрхийн гишүүдийн тоо

№		Тоо	Хувь
1	1,00	8	11,4
2	2,00	18	25,7
3	3,00	10	14,3
4	4,00	6	8,6
5	5,00	16	22,9
6	6,00	8	11,4
7	7,00	4	5,7

Үүнээс ажил эрхэлдэг өрхийн гишүүдийн тоо

№		Тоо	Хувь
1	0	14	23,3
2	1,00	30	50,0
3	2,00	10	16,7
4	3,00	4	6,7
5	5,00	2	3,3

17. Өрхийн сарын дундаж орлого

№		Тоо	Хувь
1	Орлого янз бүр, мал малладаг	18	24,3
2	300000 хүртэлх	24	32,4
3	300001-600000	16	21,6
4	600001-900000	14	18,9
5	900001-1200000	2	2,7
6	1200001 дээш	18	24,3

Гэрийн хаяг

№		Тоо	Хувь
1	СХД	2	2,8
2	Зуунмод	12	16,7
3	Заамар	2	2,8
4	БГД	2	2,8
5	Баянчандмань	4	5,6
6	Алтанбулаг	2	2,8
7	Баян	2	2,8
8	НД	8	11,1
9	БЗД	2	2,8
10	Дэлгэрхаан	4	5,6
11	Эрдэнэсант	12	16,7
12	Борнуур	12	16,7
13	Жаргалант	8	11,1

Хавсралт № 2. Монгол Улсын шүүхийн шинэтгэлүүд буюу шүүхийн тогтолцоонд орсон өөрчлөлтүүд

Он	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх	Тусгай шүүх	Дагнасан шүүх	Төрөлжсөн шүүх
1921-1923	Ардын түр Засгийн газрын Шүүх яам ⁶⁴					
1923-1926	Шүүх Яам, Хошуудын Тамгын газрын зарга шийтгэх хэлтэс			Комендатын хороо /цэргийн шүүх/ Цаг зуурын шүүх ⁶⁵		
1925 ⁶⁶	Аймаг хошуудын шүүх		Улсын дээд шүүх	Цэргийн шүүх, Төрд онц аюултай хэргийг таслан шийдвэрлэх түр цагийн шүүх		
1926 ⁶⁷ - 1940	Хошуудын жинхэнэ ардын шүүн таслах газар	Аймаг, хотын шүүн таслах газар		Цэргийн шүүх таслах газар, Түр зуурын шүүх таслах газар		
1940 ⁶⁸ -1960	Ардын шүүх таслах газар, Олон нийтийн шүүх ⁶⁹	Улаанбаатар хотын шүүх таслах газар, Аймгуудын шүүх анги	Дээд шүүх таслах газар			

⁶⁴ “Ардын түр Засгийн газраас 1921 оны 7 дугаар сарын 10-нд Шүүх яамыг байгуулсан нь тус улсад жинхэнэ ардын шүүн таслах байгууллагыг байгуулж ажиллуулах нөхцөлийг зохион байгуулалтын хувьд бүрдүүлсэн гэж үздэг” Ж.Болдбаатар, Д.Дундээжанпан. МУ-ын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ хот. 1997 он.

⁶⁵ Ардын Засгийн газрын 42 дугаар тогтоолоор байгуулагдаж 1923-1930 он хүртэл үйл ажиллагаа явуулж байсан.

⁶⁶ 1925 онд хуралдсан Улсын II Их Хурлаас гаргасан “Шүүх таслах шааруудыг зохион байгуулах тухай” тогтоолын дагуу байгуулсан шүүхүүд.

⁶⁷ “БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах тухай” дүрмийг Бага хурлын тэргүүлэгчид 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр багасан нь тус улсын шүүхийн байгууллагын төрийн бие даасан тогтолцоо болгох эрх зүйн үндэс болсон.

⁶⁸ БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 7 дугаар бүлэгт шүүхийн тогтолцоог тогтоосон.

⁶⁹ Шүүн таслах ажиллагаанд олон нийтийг оролцуулах зорилго бүхий “ олон нийтийн шүүх”-ийг БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1943 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 20 дугаар тогтоолоор байгуулсан.

Он	Анхан шатны шүүх	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүх	Тусгай шүүх	Дагнасан шүүх	Төрөлжсөн шүүх
1960 ⁷⁰ -1992	Хэсгийн шүүх ⁷¹ болон районы шүүх ⁷²	Аймаг, хотын шүүх	БНМАУ-ын Дээд шүүх	Хязгаарын ба, дотоодын цэргийн шүүх ⁷³ төмөр замын/		
1993 ⁷⁴ - 2002	Сум болон сум, дүүрэг буюу дүүргийн шүүх	Аймаг, нийслэлийн шүүх	Улсын дээд шүүх			
2002 ⁷⁵ -2013	Дүүргийн, Сум, сум дундын шүүх	Аймаг, нийслэлийн шүүх	Улсын Дээд шүүх		Захиргааны хэргийн шүүх ⁷⁶	Үндсэн хуулийн цэц
2013 оноос эхлэн МУ-ын шүүхийн тогтолцоонд өөрчлөлт орж, тойргийн журмаар үйл ажиллагаа явуулах болсон. Анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүдэд иргэний болон эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаа дагнасан хэлбэрээр явагдана						
2013 -	Дүүргийн, Сум, сум дундын шүүх	Аймаг, нийслэлийн шүүх	Улсын Дээд шүүх			Үндсэн хуулийн цэц

⁷⁰ 1960 оны Үндсэн хуулиархи БНМАУ-ын шүүх ийн тогтолцоо

⁷¹ БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 315 дугаар зарлигаар Улаанбаатар хотоос бусад газар /аймгуудын/ Ардын хэсгийн шүүхүүдийг таган буулгаж оронд нь аймгийн нүүдлийн шүүхүүдийг байгуулсан.

⁷² БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1965 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 117 дугаар зарлигаар хотын хэсгийн шүүхийг таган буулгаж, район тус бүрд ардын шүүх байгуулав.

⁷³ АИХ-ын Тэргүүлэгчдийн 1972 оны 5 дугаар сарын 8-ний өдрийн 92 дугаар зарлиг.

⁷⁴ 1993 онд батлагдсан “Шүүхийн тухай хууль”-иар МУ-ын шүүхийн тогтолцоо

⁷⁵ “Үндсэн хуулийн мөдлөг” Б.Чимид. УБ хот. 2008 он. 312-р тал.

⁷⁶ УИХ 2002 оны 12 дугаар сарын 26-нд баталсан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай” хуулиудыг баталж 2004 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсөн

Хавсралт №3

Төв аймгийн Зуун мод сум дахь шүүхийн төсөв

	2012	2013	2014	2015
Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1
УРСГАЛ ЗАРДАЛ	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	584,958.9	731,116.1	1,195,190.8	1,105,167.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	449,180.3	531,912.5	902,977.3	867,598.0
Үндсэн цалин	400,936.0	481,223.8	875,618.7	803,697.0
Унаа хоолны Хөнгөлөлт	7,792.0	10,026.0	10,890.0	45,012.0
Урамшуулал	7,786.7	7,786.7	16,468.6	18,889.0
Гэрээт ажлын цалин	32,665.6	32,876.0	0.0	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,442.9	59,011.3	99,328.9	95,435.9
Тэтгэврийн даатгал	31,463.7	37,552.6	63,208.9	60,731.9
Тэтгэмжийн даатгал	2,247.4	4,291.7	7,223.6	6,940.8
ҮОМШ-ний даатгал	4,494.8	5,364.7	9,030.1	8,676.0
Ажилгүйдлийн даатгал	2,247.4	1,073.0	1,806.3	1,735.2
Эрүүл мэндийн даатгал	8,989.6	10,729.3	18,060.0	17,352.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,416.1	44,290.0	57,164.2	60,614.2
Гэрэл, цахилгаан	2,700.6	3,550.0	12,697.0	7,068.2
Түлш, халаалт	33,553.0	38,700.0	36,673.0	50,556.0
Цэвэр, бохир ус	2,162.5	2,040.0	2,184.0	2,990.0
Байрны түрээс	0.0	0.0	5,610.2	0.0
Хангамж, бараа материалын зардал	30,501.7	43,852.5	46,371.5	41,811.0
Бичиг хэрэг	7,475.4	13,659.3	15,652.0	9,400.0
Тээвэр, шатахуун	11,494.4	13,380.9	11,521.5	9,611.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,434.8	13,752.3	15,652.0	16,000.0
Ном, хэвлэл	700.8	560.0	546.0	800.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	396.3	2,500.0	3,000.0	6,000.0

Нормативт зардал	250.0	1,500.0	1,456.0	700.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	250.0	1,500.0	1,456.0	700.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000.0	33,653.1	69,926.8	21,196.0
Багаж, техник, хэрэгсэл	0.0	0.0	0.0	3,996.0
Тавилга	0.0	16,259.1	2,202.8	0.0
Урсгал засвар	2,000.0	17,394.0	67,724.0	17,200.0
Томилолт, зочны зардал	8,835.9	7,883.2	6,937.2	7,000.0
Дотоод албан томилолт	8,835.9	7,883.2	6,937.2	7,000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,332.0	8,013.5	9,928.9	8,752.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,884.0	6,405.5	7,084.9	5,550.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	0.0	768.0	800.0
Даатгалын үйлчилгээ	0.0	1,140.0	1,713.0	1,819.0
Тээврийн хэрэгслийн татвар	0.0	300.0	0.0	0.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	300.0	0.0	45.0	165.0
Мэдээллийн технологийн үйлчилгээ	130.0	150.0	300.0	400.0
Газрын төлбөр	18.0	18.0	18.0	18.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.0	1,000.0	1,100.0	2,060.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.0	1,000.0	500.0	560.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	0.0	600.0	1,500.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,600.0	9,908.0	17,012.0	30,789.0
Бусад урсгал шилжүүлэг	4,600.0	9,908.0	17,012.0	30,789.0
Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,600.0	9,408.0	860.0	486.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	500.0	500.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	0.0	0.0	20,283.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	15,652.0	10,020.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1
Улсын төсвөөс санхүүжих	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1
Улсын төсвөөс санхүүжих	589,558.9	741,024.1	1,212,202.8	1,135,956.1